



МОНГОЛЫН
ХУУЛЬЧДЫН
ХОЛБОО

Хуульчдын
Холбоо

ХОРООДЫН ТАЙЛАН

2023 оны 07 дугаар сарын 04

Улаанбаатар хот



МОНГОЛЫН

ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Нэг. Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны гишүүдийг шинээр сонгох ажлыг зохион байгуулах

Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусч, гишүүдийг шинээр сонгох нэр дэвшүүлэх ажиллагааг 03 дугаар сарын 10-17-ны өдрүүдэд зохион байгуулав. Шалгалтын хороонд нэр дэвшүүлэх тухай албан бичгийг Шүүгчдийн хороо, Прокурорын хороо, Өмгөөлөгчдийн хороонд хүргүүлсэн ба хуульч профессоруудын төлөөлөлд нэр дэвшигчдийг Хуульчдын холбооны сайт дээр нээлттэй байршуулж, хүсэлтийг хүлээн авсан. Зохих шаардлагыг хангасан нэр дэвшигчдийн материалыг Зөвлөл хариуцсан мэргэжилтэнд өгч, 03 сарын 25-ны өдрийн Зөвлөлийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэв.

Зөвлөлийн ээлжит бус хурлаас Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны даргаар Б.Амарбаясгалан, гишүүдээр Т.Мөнх-Эрдэнэ, Д.Дамдинсүрэн, Б.Эрхэмбаяр, Т.Золбоо, Д.Оросоо, М.Мөнхбат, Б.Буянхшиг, В.Оюумаа, С.Энхбаяр нарыг батламжлав.

Дээрх Зөвлөлийн хурлаар нэрээ дэвшүүлсэн бусад хуульчид олонхийн санал авч чадаагүй тул Хорооны гишүүдийг бүрдүүлэх дахин сонгуулийг 04 сарын 17-26-ны өдрийн хооронд зохион байгуулав. Зөвлөлийн ээлжит хурал 04 сарын 28-ны өдөр хуралдаж Хорооны хуульч профессорын төлөөлөлд Б.Баасандоржийг батламжлав.

Хоёр. Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны хурал

1.Хорооны ээлжит бус хурал шинэ гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр 04 сарын 07-ны өдөр хуралдаж, тус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

- Хорооны сүүлийн 3 жилд хийж гүйцэтгэсэн ажлын талаарх товч мэдээлэл
- “Чиг үүргийн хороодын үйл ажиллагаа явуулах нийтлэг журам”-ын товч танилцуулга
- Шалгалтын хорооны даргыг сонгох
- Хорооны 2023 оны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө
- Хорооны хуралд гишүүд ирц бүрэн оролцсон бөгөөд гишүүдийн олонх дэмжсэнээр Шалгалтын хорооны даргаар Болдын Амарбаясгаланг сонгов.

2.Хорооны ээлжит хурал 04 сарын 17-ны өдөр хуралдаж, хурлаар дараах асуудлыг хэлэлцэв. Үүнд:

- Хорооны 2023 оны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө
- 2022 оны шалгалтаас хойш нэмэлт, өөрчлөлт орсон, шинээр батлагдсан хуулиудын жагсаалт, 2022 оны сорилгын шалгалтын тестийн сангийн талаар мэдээлэл хийх
- 2022 оны Сорилгын шалгалтын тестийг хянах ажлыг гишүүдэд хуваарилах, хугацаа товлох



ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

- Хуульчийн шалгалтын бодлого бодох, шалгах нэгдсэн стандарт тогтоох зорилгоор захиргаа, иргэн, эрүүгийн бодлогын аргачлал боловсруулах ажлын хэсэг байгуулах

Хорооны хуралд гишүүд ирц бүрэн оролцож дараах шийдвэрийг гаргав. Үүнд:

- Хорооны 2023 оны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэн батлав.
- 2022 оны шалгалтаас хойш нэмэлт, өөрчлөлт орсон, шинээр батлагдсан хуулиудын жагсаалт, 2022 оны сорилгын шалгалтын тестийн сангийн талаар хорооны гишүүдэд мэдээлэл хийв.
- 2022 оны Сорилгын шалгалтын тестийг хянах ажлыг Хорооны 9 гишүүнд хуваарилав.
- Хуульчийн мэргэжлийн шалгалтын бодлого бодох, шалгах нэгдсэн стандарт тогтоох зорилгоор захиргаа, иргэн, эрүүгийн бодлогын аргачлал боловсруулах ажлын хэсгийг 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулав.

3.Хорооны ээлжит бус хурал 06 сарын 13-ны өдөр цахимаар хуралдаж, дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

- Хуульчийн мэргэжлийн шалгалтын тов тогтоох тухай саналыг Зөвлөлөөр оруулах тухай
- Хуульчийн мэргэжлийн шалгалтын хураамж нэмэх асуудлаар судалгаа хийх ажлын хэсэг байгуулах тухай хэлэлцэж Хуульчийн мэргэжлийн шалгалтыг 2023 оны 10 дугаар сарын 23-наас 28-ны өдрүүдэд зохион байгуулахаар хэлэлцэж тогтоон, Зөвлөлд хүргүүлэх саналаа тодорхойлов. Мөн Хуульчийн мэргэжлийн шалгалтын хураамжийг нэмэх асуудлаар судалгаа хийх Ажлын хэсгийг Ш.Жолбарс, З.Оюун-эрдэнэ, Г.Оюунболд, Б.Баасандорж, Д.Оросоо нарын бүрэлдэхүүнтэй байгуулав.

Гурав. Хуульчийн мэргэжлийн шалгалтын Сорилго болон бодлого бодох аргачлалын гарын авлага гаргах бэлтгэл ажлын хүрээнд

Хуульчийн мэргэжлийн шалгалтын сорилгын хураамж бэлтгэн гаргах бэлтгэл ажлын хүрээнд Шалгалтын хорооны 9 гишүүн 2022 оны сорилгын номонд орсон 3518 тестэд холбогдох хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой хяналтыг хийж, 195 тест шинээр зохиолгов. Хуульчийн мэргэжлийн шалгалтын сорилгын эмхтгэл-2023 ном эх бэлтгэл, хэвлэлтийн өмнөх хяналтын ажилдаа явж байна.

Хуульчийн мэргэжлийн шалгалтын Иргэн, Эрүү, Захиргааны эрх зүйн бодлого бодох аргачлалыг сайжруулах, шинэчлэх ажил хийгдэж, номонд орох 2 шинэ бодлого зохиох ажил хийгдэж дуусаад байна. Одоогоор бодлогын аргачлал, шинээр зохиосон бодлогуудыг нэгтгэх, хянах ажил хийгдэж байна.

Бодлого бодох аргачлалын талаар Улсын Дээд шүүхийн шүүгч Баярмаа, Батцэрэн, Банзрагч шүүгч нартай Хорооны гишүүн Буянхишиг, Золбоо, Мөнх-Эрдэнэ нар оролцсон уулзалтыг 3 удаа Дээд шүүхийн байранд зохион байгуулав.

Дөрөв. Бусад ажил

1. Хуульчдын холбооны 10 жилийн ойг угтан зохион байгуулсан “Хуульчдын шилжин явах цом-2023” спортын 6 төрөлт тэмцээнд Шалгалтын хорооны гишүүдээс боулинг, ширээний теннисний төрөлд баг бүрдүүлэн оролцож, ширээний теннисний эрэгтэй ганцаарчилсан төрөлд хорооны гишүүн Д.Дамдинсүрэн хүрэл медаль авсан.

Хуульчдын холбооноос санаачлан “Хуульчдын төгөл”-тэй болох аяны хүрээнд хорооны гишүүд идэвхтэй оролцож Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 3 мод тарив.

ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.3-д “хуульчийн үргэлжилсэн болон албан бус сургалтыг зохион байгуулах, багц цагийг тооцох”, Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хурлын 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журамд заасан бүрэн эрхийн дагуу үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сургалтын хороо 2022 онд Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчдын Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар хүлээсэн үүрэг болох хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, багц цаг хангах үүргийн биелэлтийг хангуулах, хуульчдын мэдлэг, мэргэшлийн түвшин, ур чадварыг хууль эрх зүйн шинэчлэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөрөөр үргэлжилсэн сургалт зохион байгуулах үндсэн зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийсэн байна.

1. Сургалтын хорооны хурал

- Сургалтын хороо нь 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хурал
- Сургалтын хорооны 2023 оны 04 дугаар сарын 06 өдрийн хурал
- Сургалтын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хурал
- Сургалтын хорооны 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн хурал

2. Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах хүрээнд

- Шинэ хуульчдын сургалт
- Хуульчийн үргэлжилсэн сургалт 2023 оны 03 сарын 30, 31
- Үндсэн лекц-1 “ЗЕХ 47 дугаар зүйл”
- Хуульчийн үргэлжилсэн сургалт (нэг багц цаг)
- Хуульчийн үргэлжилсэн цахим сургалт
- Видео хичээлийн сургалтын хөтөлбөр боловсруулах ажил
- Сургагч багш чадавхжуулах сургалт

2.1. Бусад байгууллагатай хамтарсан сургалт

- Татварын ерөнхий газартай хамтарсан “2022 оны татварын тайлан ба ХАОАТ, НӨАТ-ыг тайлагнах нь” сэдэвт сургалт,
- Авлигатай тэмцэх газрын албан хаагчдад вебинар сургалт,
- “Олон улсын Арилжааны арбитр”-ын сертификат олгох сургалт,
- Шүүхийн сахилгын хорооны сургалт,



ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

- ЛГБТ төвтэй хамтарсан сургалт,
- Хуулийн төсөл боловсруулагч бэлтгэх сургалт,
- Менторшип хөтөлбөрийн менти нарын сургалт,
- Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх хуульчдад эрх олгох сургалт,
- Татварын мэргэшсэн хуульч бэлтгэх сургалт,
- “Эрх зүй ба технологи -модуль II” сургалт,
- Сонгинохайрхан дүүргийн прокурорын газарт хуульчийн үргэлжилсэн сургалт

2.2.Орон нутгийн сургалт-2023

- Өвөрхангай, Баянхонгор, Төв аймагт хуульчийн үргэлжилсэн сургалтыг зохион байгуулав.

Нэг.Сургалтын хорооны хурал

1.Сургалтын хороо нь 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хуралдаж, дараах асуудлыг хэлэлцсэн. Үүнд:

д/д	2023 онд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрүүд	Багц цаг	Сургалтын хэлбэр	Магадлан итгэмжилсэн огноо	Хөтөлбөр боловруулсан
1.	Хуульчдын судалгааны арга зүйг чадавхжуулах нь	1 багц цаг	Танхим	2023.02.03	Б.Мөнхдорж Хууль зүйн доктор, дэд профессор
2.	Рационал сэтгэлгээ	2 багц цаг /Нэг удаа 3 цаг. 30 мин 1 цаг гэж тооцсон/	Танхим болон цахим	2023.02.03	Г.Эрдэнэбат Сургагч багш
3.	Цахим орчин дахь зохиогчийн эрхийн хамгаалалт	0,5 багц цаг Нэг удаа 3 цаг. 30 мин 1 цаг гэж тооцсон/	Танхим болон цахим	2023.02.03	Д.Эрдэнэчимэг Хууль зүйн ухааны доктор, дэд профессор

ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

2.Сургалтын хорооны 2023 оны 04 дугаар сарын 06 өдрийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэв. Үүнд:

- Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны даргаар хуульч Б.Өнөрмааг олонхийн саналаар сонгож, томилсон.
- “Монгол, АНУ-д Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх ажиллагаа” сургалтын хөтөлбөрийг магадлах эсэх асуудлыг хэлэлцэж дахин сайжруулахаар буцаасан.
- Олон Улсын Арилжааны арбитрын семинарт багц цаг тооцох тухай асуудал хэлэлцэж 2 багц цаг тооцохоор шийдвэрлэсэн.
- Хуульчдаас ирсэн хүсэлтийн дагуу багц цаг тооцох асуудлын дагуу багц цаг тооцсон

3.Сургалтын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

№	Хэлэлцсэн асуудал	Шийдвэрлэсэн байдал
Хөтөлбөр магадлан итгэмжлэх тухай		
1.	Татварын мэргэшсэн хуульчдын нийгэмлэгээс бэлтгэн ирүүлсэн “Татварын мэргэшсэн хуульч бэлтгэх” нийт 9 хөтөлбөр магадлан итгэмжлэх тухай	- Магадлан итгэмжилсэн - Багцаар нь 3 кр тооцох - Хугацаатай сайжруулах даалгавар өгөх
2.	Сургагч багш Д.Энх-Амгалангаас бэлтгэн ирүүлсэн “Байгууллага, компанийн дотоод аюулгүй байдлыг хангах” хөтөлбөр магадлан итгэмжлэх тухай	Албан бус сургалтын журамд заасан зорилгод нийцсэн сургалт байх тул Хуульчдын холбооны Тамгын газартай холбогдож төлбөртэй болон төлбөргүйгээр кр-гүй зохион байгуулах эрхийг олгож шийдвэрлэсэн
3.	Сургагч багш Г.Оюунболдоос бэлтгэн ирүүлсэн “Хүүхэд хамгаалал ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” хөтөлбөр магадлан итгэмжлэх тухай	Өмнө орсон хуульчдад орсон нийтлэг сургалттай сэдэв давхцаж байх тул сэдвээ илүү нарийвчилж ирүүлэх. Албан бус сургалтын журмын хэрэгжилтийг хангаж сургалтаа зохион байгуулах. 4 цагаар 0.5 кр ээр батлах томьёоллоор.
Багц цаг тооцох тухай		
4.	Д.Золжаргал, Э.Ариунбаяр нараас ирүүлсэн багц цаг дүйцүүлэн тооцох тухай	Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журмын /шинэ/ 6 дугаар зүйлийн 6.2.10-т “Гадаад улсад ижил төстэй сургалтад хамрагдсан хуульч нь тус сургалтад хамрагдахаасаа өмнө эсхүл сургалтад хамрагдсаныхаа дараа тухайн сургалтынхаа хөтөлбөрийг Сургалтын хороогоор хэлэлцүүсний үндсэн дээр сургалт зохион байгуулсан гадаад улсын байгууллагаас ирүүлсэн нотлох баримтыг үндэслэн багц цагт тооцуулж болно.” гэж заасны дагуу 1 багц цаг тооцсон.
Бусад асуудал		
5.	“Хуульчдын холбооны шилжин явах цом-2023” тэмцээнд баг бүрдүүлж оролцох тухай	Баг бүрдүүлэн оролцохоор шийдвэрлэсэн



ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

4. Сургалтын хорооны 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

№	Хэлэлцсэн асуудал	Хүсэлт ирүүлсэн хуульч	Шийдвэрлэсэн
Хөтөлбөр магадлан итгэмжлэх тухай			
1.	Виртуал хөрөнгө, түүнд суурилсан үйлчилгээний эрх зүйн зохицуулалт	Г.Давааням	Сайжруулахаар буцаасан
2.	Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, түүний эерэг ба сөрөг үр дагавар: Онол арга зүй, практик хэрэглээ, харьцуулсан судлал	Ш.Цогтоо	Магадлан итгэмжилсэн. 1 багц цаг
3.	Кибер орчинд үйлдэгдэх гэмт хэрэг, түүний эрх зүйн зохицуулалт	Б.Баялагмаа, Б.Наранцэцэг, Б.Анирмаа нар	Албан бус сургалтын журмын хэрэгжилтийг хангаж сургалтаа зохион байгуулах боломжтой
4.	Өв залгамжлах харилцаа, хуульд зааснаар өвлөх	А.Оюунчимэг	Сайжруулахаар буцаасан.
5.	Дижитал шилжилтийн эрх зүйн орчин ба кибер аюулгүй байдал	Г.Даваадорж	Магадлан итгэмжилсэн. 1 багц цаг
6.	Эрх зүй ба технологи	Д.Ганхүрэл	Дараагийн хурлаар хэлэлцэхээр хойшлуулсан.
7.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шийдвэрт хууль зүйн дүгнэлт хийх	Ц.Насанбат	Магадлан итгэмжилсэн. 0.5 багц цаг
Бусад			
8.	Хуульчдын холбооны сургагч багшийн урамшуулал, багц цагийн төлбөрийг нэмэх саналыг Зөвлөлд хүргүүлэх асуудал	Г.Оюунболд, Б.Эрдэнэ-Очир гишүүд судалгаа танилцуулсан	2023.06.19 хурлын саналыг тусгаж дахин сайжруулах
9.	Багц цаг тооцуулах тухай		Тооцсон

ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Хоёр: Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах хүрээнд

Шинэ хуульчдын сургалтыг 2023 оны 01 сарын 30, 31-ний өдөр, 02 сарын 02,03, 06, 07-ны өдөр тус тус зохион байгуулж, “Үндсэн хуулийн үзэл баримтлал” сэдвээр МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, доктор Б.Гүнбилэг, **“Хуульчийн ёс зүй”** сэдвээр Монголын Хуульчдын холбооны сургагч багш, хууль зүйн ухааны магистр Ц.Азбаяр, “Жендэрийн ойлголт, Жендэрийн ялгаварлан гадуурхалт ба жендэрт суурилсан хүчирхийлэл, Жендэрт суурилсан хүчирхийллийн хэргүүд-нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах” сэдвээр Монголын Хуульчдын холбооны сургагч багш, **“Монфемнет”** үндэсний сүлжээний ерөнхий зохицуулагч Д.Энхжаргал нар хичээл заасан ба сургалтад давхардсан тоогоор 709 хуульч хамрагдсан байна.


Хуульчийн үргэлжилсэн сургалт 2023 оны 03 сарын 30, 31-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд сургалтад ЦЕГ-ийн Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч, докторант Д.Энх-Амгалан “Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт” сэдвээр, ДХИС-ийн багш, Хууль зүйн ухааны доктор М.Ванчигмаа “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэл” сэдвээр, УЕПГ-ын дэргэдэх Сургалт судалгааны хүрээлэнгийн Судалгааны албаны дарга, ахлах прокурор Б.Мөндорж **“Монгол улс дахь гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох академик судалгааны төсөл хэрэгжүүлсэн үр дүн”, “Хууль зүйн судалгаанд математик статистикийн аргыг хэрэглэсэн кейс дээр ажиллах нь”, “Хууль зүйн судалгааны арга зүй, түүний онцлог”, “Судалгааны ажлын төлөвлөлт хийх нь”** сэдвүүдийн хүрээнд нийт 42 хуульч хамрагдлаа.

“Захиргааны акт илт хуульч бус болох нь” үндсэн сэдвийн хүрээнд **“ЗЕХ-ийн 47 дугаар зүйлийг хэрэглэх аргачлалыг онол, практик хослуулан заах нь”** танхимын сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгууллаа. Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл сургалтыг нээж, үндсэн лекцийн талаар мэдээлэл өглөө. Сургалтыг Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн Т.Мөнх-Эрдэнэ, Өмгөөллийн Анта Партнерс ХХК-ийн ерөнхий захирал, Өмгөөллийн нөхөрлөлийг дэмжих хорооны тэргүүн Д.Түвшинтамир нар удирдан явуулсан бөгөөд сургалтад Монголын Хуульчдын холбооны гишүүн 40 гаруй хуульч оролцлоо. Сургалтад хамрагдсан хуульчдад 1 кредит багц цаг тооцов. Үндсэн лекц сургалтыг шүүгч, өмгөөлөгч хамтран заасан бөгөөд сургалтын явцад гишүүн хуульчид сонирхсон асуултаа асууж, харилцан ярилцан, санал бодлоо солилцов. Сургалтад оролцогчдын зүгээс сургалтын арга зүй шинэлэг, сургалтын чанар, үр өгөөж ач холбогдолтой байсныг онцолж цаашид хуульчийн сургалтын арга барилыг өнөөдрийн сургалтын жишгээр орохыг санал болголоо.





ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО



2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр “Цахим гэмт хэрэг”, “Хүүхэд хамгаалал ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр сургагч багш, Г.Оюунболд нэг багц цагийн хуульчийн үргэлжилсэн сургалтыг зохион байгуулж 35 хуульч хамрагдав.

Цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбоотойгоор вебинар сургалт цэсээр дамжуулан 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр “Цахим гэмт хэрэг” сэдвээр сургагч багш Г.Оюунболд, “Барилга болон уул уурхайн салбар дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны эрүүгийн эрх зүйн хамгаалалт: гадаад орны туршлага” сэдвээр сургагч багш Г.Оюунбаяр нар вебинар сургалт орж нийт 28 хуульч хуульчийн үргэлжилсэн цахим сургалтад хамрагдав.

Цахим сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр “Стресс, стресс менежмент” сэдвээр сургагч багш М.Цэрэнбат нийт 23 хуульчдад заасан.

Видео хичээлийн санг баяжуулах ажлыг эхлүүлэн Ханнс зайделийн сантай хамтран “Үндсэн лекц-1” болон “Үндсэн лекц-2” цуврал лекц бэлтгэж сайтын цахим сургалт цэсэд байршуулсан.





ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Монголын Хуульчдын холбоо, Азийн сан хамтран Хуульчдын Холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын сургагч багш нарын хичээл заах арга, хэлбэрийг сайжруулах, туршлага, санал солилцох зорилгоор **“Сургагч багш чадавхжуулах”** нэг өдрийн сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан. Сургалтыг **“Суралцагчдыг идэвхжүүлэх зарим аргууд”, “Сургалтын слайд оновчтой бэлдэх аргачлал”, “Сургалт үр дүнтэй зохион байгуулах арга, туршлага”, “Багийн сэтгэл зүй ба харилцааны менежмент”, “Сургалт үр дүнтэй зохион байгуулах арга, туршлага- Хууль зүйн мэргэжлийн хичээлийн жишээн дээр”** болон **“Сургалтын жишиг хөтөлбөр боловсруулахад анхаарах зүйл”** сэдвээр зохион байгуулсан ба Хуульчдын холбооны Сургалтын хорооны гишүүд, Хуульчдын холбооны сургагч багш нар, Азийн сангийн төлөөллөөс бүрдсэн нийт 50 сургагч багш нар хамрагдсан.



БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТАРСАН СУРГАЛТ

Хуульчдын холбоо, Татварын Ерөнхий газар хамтран **“2022 оны татварын тайлан ба ХАОАТ, НӨАТ-ыг тайлагнах нь”** сэдэвт сургалтыг 2023 оны 02 дугаар сарын 04-ний өдөр тахим болон цахимаар зохион байгуулсан. 2022 оны татварын тайлан тушаах хугацаа 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр дуусахтай холбоотойгоор сургалтыг ТЕГ-ын НӨАТ-ын хэлтсийн дарга Д.Мөнхтуул, ТЕГ-ын улсын байцаагч Ц.Ундармаа нар удирдан явуулсан бөгөөд танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж танхимаар 15 хүн, цахимаар 30 хүн хамрагдсан. Сургалтын үеэр оролцогчдын асуултад хариулж, тайлан илгээхтэй холбоотой практик зааварчилгаа өгсөн.



2023 оны 03 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд Авлигатай тэмцэх газрын 42 хуульчид “Эрүүгийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа” сэдвээр Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга, сургагч багш, Хууль зүйн ухааны доктор, судлаач Б.Батзориг, **“Цахим гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх арга”** /Хувь хүн болон байгууллагын кибер аюулгүй байдал, Тоон гарын үсэг/ сэдвээр Монголын Хуульчдын холбооны сургагч багш, Эрүүгийн эрх зүйн хорооны гишүүн, Хууль зүйн магистр Г.Оюунболд, **“Захиргааны гэрээг иргэний эрх зүйн болон холимог төрлийн гэрээнээс ялгах нь”** сэдвээр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, сургагч багш, Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн, Хууль зүйн ухааны магистр Т.Мөнх-Эрдэнэ, “Компанийн засаглал” сэдвээр Монгол Улсын гавьяат эдийн засагч, сургагч багш, судлаач Д.Байлхүү нар хичээл заасан. Уг сургалтад тус газрын хуульчид хамрагдаж 2 багц цагийг тооцов.



ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Хуульчдын холбооны хүсэлтээр АНУ-ын Худалдааны яамны дэргэдэх Арилжааны эрх зүйн хөгжлийн хөтөлбөр (**Commercial Law Development Program**)-ийн дэмжлэгтэйгээр 2023 оны 04 дүгээр сарын 17, 18-ны өрүүдэд “Олон улсын Арилжааны арбитр”-ын сертификат олгох сургалт зохион байгуулсан. АНУ-ын Худалдааны яамны дэргэдэх Арилжааны эрх зүйн хөгжлийн хөтөлбөр (**Commercial Law Development Program**) нь хөгжиж буй улс орны бизнесийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус хөтөлбөр хэрэгжиж буй орны хуульч, судлаач, төрийн албан хаагчдад зориулан арилжааны эрх зүйн чиглэлээр сургалт явуулах, бусад оронд хэрэгжсэн сайн жишгийг танилцуулах, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг хууль зүйн техник туслалцаа үзүүлдэг. Сургалтыг нээж Арилжааны эрх зүйн хөгжлийн хөтөлбөрийн зөвлөх Гришма Прадхан, АНУ-ын Элчин сайдын яамны Эдийн засгийн хэлтсийн дарга Майкл Ричмонд, Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл нар үг хэлсэн. Мөн сургалтын хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс дахь арбитрын эрх зүйн орчны талаар Монголын Олон улсын арбитрын арбитрч, МУИС-ийн ХЗС-ийн дэд профессор, доктор Т.Мэндсайхан илтгэл хэлэлцүүлсэн. Сургалтыг Сингапур, Япон Улсад үйл ажиллагаа явуулдаг **Shearman & Sterling, DLA Piper** олон улсын хуулийн фирмийн хуульчид Эммануэл Жакоми, Тонм Андрототис, Артис Страпенис нар явуулсан. Сургалтад нийт **55** хуульч хамрагдсан.



МОНГОЛЫН
ХУУЛЬЧДЫН
ХОЛБОО



CLDP
COMMERCIAL LAW DEVELOPMENT
PROGRAM

“ОЛОН УЛСЫН АРИЛЖААНЫ АРБИТРЫН СУРГАЛТ”



EMMANUEL JACOMY
“Shearman & Sterling” олон улсын
хуулийн фирмийн гишүүн

- Олон улсын бизнес, эдийн засгийн их сургуулийн (UIBE) туслах профессор, Бээжингийн Цинхуа их сургуулийн зочин профессор.
- Эммануэль нь Олон Улсын Барын холбооны Арбитрын асуудал хариуцсан хороо болон ажлын хэсгийг удирдан ажилладаг.
- Хятадын Олон Улсын Худалдааг Дэмжих Зөвлөл (CCPIT) болон Бээжингийн технологийн хүрээлэн (BIT) хамтран байгуулсан Маргаан шийдвэрлэх олон улсын хүрээлэнгийн (IIDPS) шинжээчдийн зөвлөлийн хорооны гишүүн.



TONY ANDRIOTIS
“DLA Piper” олон улсын хуулийн
фирмийн гишүүн

- DLA Piper-ийн Токио дахь салбарын олон улсын арбитрын багийг удирддаг.
- Олон улсын арбитрын томоохон төв, шүүхүүдэд Японы томоохон компаниудыг төлөөлөн ажиллаж байсан туршлагатай.
- Азийн олон улсын арбитрын төв, Солонгосын арилжааны арбитрын зөвлөл, Шенжинийн олон улсын арбитрын шүүх, Японы арилжааны арбитрын нийгэмлэгт арбитрчаар ажилладаг.



ARTIS STRAUPENIEKS
“Shearman & Sterling” олон улсын
хуулийн фирмийн хуульч

- Сингапур дахь Shearman & Sterling-ийн олон улсын арбитрын бүлэгт ажилладаг.
- ICC, SIAC, UNCITRAL, HKIAC зэрэг олон улсын арбитрын ихэнх дүрмийн дагуу явагдсан арбитрын ажиллагаанд ажилласан туршлагатай.



ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Шүүхийн сахилгын хорооны хуульчдад “Хуульчийн харилцаа хандлага” сэдвээр сургагч багш Ц.Азбаяр 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр сургалт зохион байгуулж 15 хуульч оролцлоо.




МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО

“ЛГБТИК+ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТ БОЛНО

Сургалтаар дамжуулан ЛГБТИК+ эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах, эрх зүйн бүх салбарт хүний эрхийн мэдрэмжтэй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх арга зүйг төлөвшүүлэх зорилгоор Хуульчдын холбоо ЛГБТ төвтэй хамтран “ЛГБТИК+ үйлчлүүлэгчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх нь” сэдэвт нэг өдрийн сургалтыг зохион байгуулах гэж байна.

Хэвч: 2023.05.17, 2023.05.18-ны өдрийн аль нэгэнд сонгон суух боломжтой
Сургалтын хамрах хурал: Нэг өдрийн хичээлд 18:20 хуульч хамрагдах



Хуульчдад ЛГБТИК+ эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах, эрх зүйн бүх салбарт хүний эрхийн мэдрэмжтэй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх арга зүйг төлөвшүүлэх зорилгоор “ЛГБТИК+ үйлчлүүлэгчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх нь” сэдэвт сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд ЛГБТ төвтэй хамтран зохион байгуулсан. Тус сургалтад 10 хуульч хамрагдав.



ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО



Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлагийн “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” дэд төсөл хамтран суралцагчдын хууль зүйн техникийн суурь мэдлэгийг бататгах, хуулийн төсөл боловсруулах арга зүй, ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх зорилготой **“Хуулийн төсөл боловсруулагчийн сургалт”**-ыг 2023 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Сургалтыг нээж Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, хууль зүйн ухааны доктор (Ph.D) П.Одгэрэл, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор (Ph.D) Л.Өлзийсайхан нар үг хэлж, Швейцарын хөгжлийн агентлагийн Хамтын ажиллагааны газрын захирал Стефани Бурри бичлэгээр мэндчилгээ дэвшүүлсэн. Сургалтад УИХ-н Тамгын газрын алба хаагчид, холбогдох яамдын мэргэжилтнүүдээс бүрдсэн 50 албан хаагч хамрагдав.

Монголын Хуульчдын холбооноос Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй Менторшип хөтөлбөр нь 3 дахь жилдээ амжилттай үргэлжлэн зохион байгуулагдаж байна. Тус хөтөлбөрийн менти нарын хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, ажлын арга барил болон харилцаа хандлагыг өөрчлөх, танилын хүрээг нэмэх зорилготой сургалт 05 сарын 16-ны өдөр зохион байгуулагдлаа. Сургалтыг нээж Сургалтын хорооны гишүүн Г.Оюунболд үг хэлсэн ба Азийн сангийн төлөөлөл төслийн ажилтан Л.Оюу, хөтөлбөрийн 19 менти сургалтад хамрагдав. Сургалтад хөтөлбөрийн менторууд болох Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Э.Энэбиш “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь, анхаарах зүйл”, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч С.Мөнхжаргал “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай ойлголт”, “Андерсон энд андерсон” ХХН-ийн партнер, арбитрч Х.Наранбулаг “Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны олон улс дахь орчин үеийн чиг хандлага”, “Хуулийн чиглэлээр гадаад улсад тэтгэлэгтэй суралцах боломж” болон “Кэйстон легал” ХХК хуулийн фирмийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал А.Мандуул “Олон улсын хуулийн фирмд ажиллах нь, ажлын арга барил, стандарт, практик”, “Хуулийн англи хэл, хууль зүйн орчуулга-тойм” зэрэг сэдвээр тус тус хичээл заалаа. Тус хөтөлбөр нь энэ оны 07 дугаар сар хүртэл үргэлжлэх юм.



ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Монголбанкны дэргэдэх Санхүүгийн зохицуулах хороотой хамтын ажиллагааг үргэлжлүүлж гэрээ байгуулахаар хэлэлцэж, **“Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх хуульчдад эрх олгох сургалт”**-ыг 2023 онд зохион байгуулахаар уулзалт хийж, санал солилцсон. Тус сургалт нь үнэт цаасны зах зээлд хууль зүйн мэргэжлийн, чанартай зөвлөгөө өгөх хуульчдыг бэлтгэх, мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилготой бөгөөд энэ удаагийн сургалтыг 16 сэдвийн хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 24, 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулав. Сургалтад 52 хуульч хамрагдсан.





ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Монголын Хуульчдын холбоо, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг хамтран татварын мэргэшсэн хуульчийн сургалт 2023 оны 05 сарын 04-ний өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдрийг дуустал нийт 64 цаг буюу 8 хоногийн сургалтыг зохион байгуулж хуульчдад батламж гардуулсан. Сургалтыг Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл нээж, нээлтэд Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн дэд ерөнхийлөгч Ү.Галмандах, Сургалтын менежментийн хорооны дарга Ч.Өнөржаргал, сургалтын албаны менежер О.Батсүх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харьцах албаны менежер Г.Цэрэндулам нар оролцов. Сургалтад 45 хуульч хамрагдаж **“Татварын мэргэшсэн хуульч”** батламж гардан авсан. Сургалтад хамрагдсан хуульчдад 3 кредит багц цаг тооцов.

Сургалт дараах агуулгыг хамрав. Үүнд:

- Татварын хуулиудын системчлэл ба хэрэглэх аргачлал
- Татвар хураах ажиллагаа, цахим систем
- Татварын удирдлага, эрсдэл хяналт шалгалтын процесс
- Татварын мэргэшсэн хуульчид тавигдах татварын онолын мэдлэг болон мэргэжлийн ёс зүйн шаардлага
- Санхүү ба Татварын тайланг уншиж ойлгох ба татварын мэдээллийг хэрэглэх нь
- НӨАТХ болон бусад хэрэглээний ба хөрөнгийн албан татварын хуулиудад анхаарах зүйлс
- Орлогын албан татвар (ХХОАТХ, ААНОАТХ) хэрэглээнд анхаарах зүйлс
- Олон улсын татварын эрх зүйн маргаан ба хуулийн хэрэглээ
- АМНАТ хэрэглээнд анхаарах асуудал
- Татварын гомдол ба маргаан таслах зөвлөлийн хянан шийдвэрлэх ажиллагаа
- Татварын маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа



ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Монголын Хуульчдын холбооны Эдийн засгийн эрх зүйн хорооны санаачлагаар Монголын Биржүүдийн нэгдсэн холбоо, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эдийн засаг, бизнесийн эрх зүйн судалгааны төв, МУИС-ийн хэрэглээний шинжлэх ухааны машин оюуны лабораторийн хамтын ажиллагааны хүрээнд “Эрх зүй ба технологи -модуль II” сургалтыг зохион байгуулсан. Дижитал шилжилтийн хүрээнд мэдээллийн технологийн хэрэглээ өсөн нэмэгдэж буйтай холбоотойгоор мэдээллийн технологид суурилсан үйлчилгээ, бүтээгдэхүүний эрх зүйн орчны талаар мэдлэгийг эзэмшүүлэх, практикт үүсэж буй тулгамдсан асуудлыг шийдвэрлэж буй арга зам, сайн туршлагын талаарх мэдээллийг олгох зэргийн бус сургалт 2023 оны 05 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад 15 хуульч оролцож 2 кредит багц цаг тооцов.



ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

ДЭМЖИГЧ БАЙГУУЛАГА

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Эдийн засаг, бизнесийн эрх зүйн судалгааны төв

МУИС-ийн ИДЭҮС-ийн
Монгол орны лаборатори

Монголын Хуульчдын Холбоо

Монголын Биржүүдийн Нэгдсэн Холбоо

**ЭРХ ЗҮЙ БА ТЕХНОЛОГИ - МОДУЛЬ II
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАНА**

СУРГАЛТ 2023 ОНЫ 5 ДУГААР САРЫН 19, 20-НЫ
ӨДРҮҮДЭД ЗОХИОН БАЙГУУЛАГДАНА.
ХЭНЭЙ ТОО ХЯАГААРТАЙ, ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН
СУРГАЛТЫН 2023 ОНЫ 2 БАГЦ ЦАГ ТООЦНО.

ДЭМЖЭЭРЭГҮЙ
МЭДЭЭЛЛИЙГ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газраас 2023 оны 06 сарын 13-ны өдөр ирсэн хүсэлтийн дагуу Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооноос тус газарт 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр сургалт зохион байгууллаа. Сургалтыг Монголын Хуульчдын холбооны сургагч багш, АШУ-ны доктор, Хууль зүйн магистр М.Цэрэнбат “**Стресс менежмент**” сэдвээр орлоо. Сургалтад 42 хуульч хамрагдаж 1 багц цагийн тооцууллаа.



ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

ОРОН НУТГИЙН СУРГАЛТ-2023

Монголын Хуульчдын холбоо нь нийслэл болон орон нутгийн хуульчдын мэдлэгийг дээшлүүлэх, эрх ашгийг хамгаалах чиг үүргийн хүрээнд орон нутгийн хуульчдад Холбооны үйл ажиллагааг таниулах, хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах зорилгоор 21 аймагт хуульчийн үргэлжилсэн сургалтыг Өвөрхангай аймагт 2023 оны 05 дугаар сарын 03, 04-ний өдөр, Баянхонгор аймагт 2023 оны 05 дугаар сарын 05, 06-ны өдөр зохион байгуулсан.

Өвөрхангай, Баянхонгор аймгийн хуульчдаас авсан судалгааны дүнд өндөр санал авсан сэдвийн дагуу хуульчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дараах хөтөлбөр боловсруулсан. Үүнд:

- “Цахим гэмт хэрэг”, “Хүүхэд хамгаалал ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр Хуульчдын холбооны сургагч багш, Зөвлөлийн гишүүн Г.Оюунболд;
- “Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт” сэдвээр Монголын Хуульчдын холбооны сургагч багш, цагдаагийн хошууч, докторант Д.Энх-Амгалан;
- “ЗЕХ §47: Захиргааны акт илт хууль бус болох нь” сэдвээр Монголын Хуульчдын холбооны сургагч багш, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Мөнх-Эрдэнэ, “Өмгөөллийн Анта Партнерс” ХХК-ийн ерөнхий захирал Д.Түвшинтамир.

Сургалтыг Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс нээж үг хэлж Өвөрхангай аймагт прокурор, өмгөөлөгч, бусад хуульчдаас бүрдсэн нийт 35 хуульч, Баянхонгор аймагт нийт 38 хуульч хамрагдсан. Сургалтын төгсгөлд хуульчдын санал хүсэлтийг сонсох, холбооны үйл ажиллагааг таниулахаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.



ХОРООНЫ ГИШҮҮДИЙН СОНГУУЛЬ

Сургалтын хорооны гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан гишүүдийг шинэчлэхээр хороодод албан бичиг хүргүүлж, 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр нэр дэвших хуульч, профессоруудыг бүртгэхээр зарыг хүргэж, Зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар хорооны гишүүдийг эцэслэн баталсан. Үүнд: Сургалтын хорооны даргаар хуульч Б.Өнөрмаа, гишүүдээр Б.Азбаяр, Д.Халиуна, Ц.Насанбат, Ц.Батболд, Ө.Эрдэнэ-Очир, Ц.Азбаяр, Г.Оюунболд, С.Болормаа, Г.Наранбаатар, В.Оюумаа, Г.Банзрагч, Т.Наранцогт.

ХУУЛЬЧДЫН ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ХОРОО

1.Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хороонд ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх

2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн Зөвлөлийн 12 дугаар тогтоолоор Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооны гишүүдийг батламжилсан. Хороонд 2 хуульчаас эрхээ хамгаалуулах хүсэлт ирүүлсэн бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Ш.Алтангадас, гишүүдээр Н.Ганболд, Ц.Мөхбат, Ш.Нарантуяа, О.Чулуунцэцэг нар ажиллаж дүгнэт гаргасан бөгөөд дүгнэлтийг хорооны гишүүдэд танилцуулан эцэслэн шийдвэрлэсэн. Эцэслэн шийдвэрлэсэн дүгнэлтийг хорооны дарга Ш.Алтангадас хүсэлт гаргасан хуульчтай холбогдож мэдээлэл хүргүүлсэн. Мөн тус хуульчийн эрхийг хамгаалахтай холбогдуулан мэдээлэл гаргасан сайт олох хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд албан бичиг хүргүүлэхээр ажиллаж байна.






ХУУЛЬЧДЫН ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ХОРОО

2. “Хуульч” мэргэжлийн болон ажил хэргийн нэр хүндийг дээшлүүлэх нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх:

Монголын Хуульчдын холбооноос 2023 оныг “Хуульчдын эрх ашгийг хамгаалах, нэр хүндийг дээшлүүлэх жил” болгон зарлахаар 2023.03.25-ны өдрийн Зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн. Энэхүү илалжиллагаатай холбоотой танилцуулгыг “Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” журмын ажлын хэсгийн гишүүн Ш.Алтангадас бэлтгэж танилцуулсан.




Мөн 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр энэ чиглэлээр гадны орны сайн туршлага судлах болон бэлтгэл ажлын хүрээнд Канад Улсын шүүгч Марк Ричардтай “Хуульчийн нэр хүнд, ёс зүй ба орчин цагийн сорилтууд сэдэвт чөлөөлт уулзалт, ярилцлагыг зохион байгуулсан.



3. Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах журам батлуулах:

Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 13 дугаар тушаалаар Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсгийн ахлагчаар хуульч, прокурор Ц.Мөнхбат ажилласан. Ажлын хэсгээс боловсруулсан журмын төслийг 2023.01.28-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар журмын төслийг хэлэлцүүлж, зөвлөлийн гишүүд болон хуульчдаас ирсэн саналуудыг нэгтгэн 2023.03.25-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж журмын төслийн танилцуулга, үзэл баримтлал, төслийг бэлтгэж зөвлөл хариуцсан мэргэжилтэн Ж.Бариаширсүрэнд хүлээлгэн өгч Зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлуулсан.



Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооны цахим хуудсыг нээж эрх ашгийг хамгаалах нөлөөллийн ажлыг хийхээр төлөвлөж байна.

ХУУЛЬЧДЫН ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ХОРОО

4. Монголын Хуульчдын холбооноос “Хуульчдын төгөлтэй болцгооё” уриан дор мод тарих ажилд оролцох:

2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Хуульчдын холбооноос зохион байгуулсан “Хуульчдын төгөлтэй болцгооё” ажлыг зохион байгуулахад хорооны гишүүдийг идэвхтэй оролцож 10 мод тарьсан.



5. Хэлэлцүүлэг зохион байгуулах

Нийгмийн даатгалын багц хуулиудын шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг Эдийн засгийн эрх зүйн хороо, Захиргааны эрх зүйн хороодтой хамтран 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Цаашид зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байна.





ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

1. Хуульчдын оюуны спортыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх:

Монголын Хуульчдын холбооны 10 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулагдсан Ерөнхийлөгчийн нэрэмжит шатрын тэмцээнийг 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Хуульчдын холбооны нийт хуульчдын дунд оюуны спортыг түгээн дэлгэрүүлэх, ур чадварыг хөгжүүлэх, туршлага солилцох зорилгоор зохион байгууллаа. Тус тэмцээнд 14 хорооны 42 тамирчин оюун ухаан, ур чадвараа сорин өрсөлдсөнөөс дараах амжилтыг үзүүллээ. Үүнд:

- Нэгдүгээр байр-Иргэний эрх зүйн хорооны баг тамирчид /М.Мөнгөнхүү, Т.Сайнбаяр, Б.Ургамалцэцэг/,
- Хоёрдугаар байр-ХЗШУХЗБД хорооны баг тамирчид /Ц.Мөнхбат, Ч.Булган, Э.Эрдэмжаргал/,
- Гуравдугаар байр-Эдийн засгийн эрх зүйн хорооны баг тамирчид /Д.Доржхорол,Ц.Мөнхбат, Г.Болормаа/,
- Дөрөвдүгээр байр- Захиргааны эрх зүйн хорооны баг тамирчид /Н.Мягмар, Н.Найгалдорж, Ц.Санжаалхам/,
- Тавдугаар байр- Прокурорын хорооны баг тамирчид /Т.Баярсайхан, Т.Мэндсайхан, Э.Пүрэвдулам/,
- Зургадугаар байр-ХНТМУАҮАЭ хорооны баг тамирчид /Д.Алтанхуяг, О.Жаргалсайхан, С.Анударь/,
- Шилдэг ахмад шатарчин- хуульч Б.Дамба, С.Чинбат, Шилдэг эмэгтэй шатарчин- хуульч, А.Уламбаяр, Тамгын газрын мэргэжилтэн Ч.Анужин, Ширээний аварга шатарчин- хуульч Ц.Мөнхбат, Т.Баярсайхан, Э.Энхжаргал, Рейтингүй шилдэг шатарчин- хуульч А.Мөнхтулга нар тус тус шалгарсан.



ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

2.Хуульч, эрдэмтэн, судлаач, хуульчдын дунд эрдэм шинжилгээний болон онол практикийн хурал, хэлэлцүүлэг зохион байгуулж үр дүнг тооцох ажлын хүрээнд:

Монголын Хуульчдын холбооны Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролыг дэмжих асуудал эрхэлсэн хороо “Өв залгамжлагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, түүний эрх зүйн хамгаалалт” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний хурлаар өв залгамжлахтай холбоотой хууль тогтоомжийн эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, тулгамдаж буй асуудлаар Соёлын яамны харьяа, Соёлын өвийн үндэсний төвийн захирал, доктор (Ph.D) Г.Энхбат, шинжээч, судлаач Б.Эрдэнэсүвд “Соёлын биет өвийн бүртгэл, түүний өмчлөл, эзэмшил, ашиглалтын өнөөгийн байдал”, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга Б.Ариунболд, Улсын ахлах бүртгэгч, судлаач Ө.Өнөрлхам, Ахлах мэргэжилтэн Э.Сүвд-Эрдэнэ “Өв залгамжлагчийн хууль ёсны эрх ашгийг улсын бүртгэлд үндэслэн хамгаалах нь”, УДШ-ийн сургалт, Судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Иргэний эрх зүйн секторын судлаач Б.Туяа, А.Нэмүүлэн “Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг өв залгамжлан авахтай холбоотой шүүхийн практикт хийсэн дүн шинжилгээ”, мөн хүрээлэнгийн шүүгчийн сургалт хариуцсан мэргэжилтэн, судлаач Х.Цэцэгмаа, Хуульч, арбитрч, докторант А.Оюунчимэг “Өв залгамжлагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудал”, Эрх зүйч, судлаач О.Эрдэнэдалай “Гэрээслэлийн эрх чөлөө ба хууль ёсоор өвлөгчийн эрх: уялдаа, харилцан хамаарал”, “Номин Холдинг” ХХК-ийн хуульч, судлаач Ж.Дөлгөөн “Хувьцаат компанийн хувьцааг өв залгамжлахад тулгамдаж буй асуудал, дүн шинжилгээ”, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, магистр Б.Баялагмаа “Nft-ийг өвлүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин”, Нотариатч, хуульч, судлаач Ч.Отгонбаяр “Өвлөх эрхийн гэрчилгээ олгоход баг хорооны Засаг даргаас олгох оршин суух тодорхойлолтын ач холбогдол, хууль зүйн үр дагавар” сэдэвт цаг үеийн чухал асуудлыг хөндсөн сонирхолтой илтгэлүүдийг хэлэлцүүлсэн бөгөөд хурлаар хэлэлцүүлсэн илтгэлүүдэд дурдсан санал, зөвлөмжийг нэгтгэж Улсын Дээд шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэнтэй хамтран эмхэтгэл гаргаж, нийтэд түгээхээр болсон. Тус эрдэм шинжилгээний хуралд 50 гаруй хуульч, өмгөөлөгч, харьяа дүүргийн нийгмийн халамжийн мэргэжилтнүүд оролцож өөрт болон ажил мэргэжлийн хүрээнд тулгарч буй асуудлаар санал солилцсон.





ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХОРОО

НЭГ. ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, ИЛТГЭЛИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Цуврал №1: “Миний дуртай захиргааны эрх зүй” чөлөөт сэдвийн хүрээнд “Төлөвлөлтийн эрх зүй яагаад чухал вэ” сэдэвт өглөөний уулзалт

Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооноос “Төлөвлөлтийн эрх зүй яагаад чухал байдаг вэ? /Гадаадын шүүхийн кейс дээр ярилцъя/” сэдэвт өглөөний уулзалтыг 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан. Тус уулзалтын панелистаар Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүгч, Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн Т.Мөнх-Эрдэнэ оролцов. Мөн захиргааны эрх зүйн чиглэлээр ажиллаж буй хуульч, судлаач, эрх зүйч нар оролцож сонирхолтой яриа өрнүүлсэн.

ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХОРОО

МИНИЙ ДУРТАЙ ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ

Цуврал уулзалт

Сэдэв: Төлөвлөлтийн эрх зүй яагаад чухал гэж? /Гадаадын шүүхийн кейс дээр ярилцъя/

Панелист: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн Т.Мөнх-Эрдэнэ

2023.02.10 07.40 a.m. Чингис хааны музей 1 давхарт, MUSE coffee shop




ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХОРОО

МИНИЙ ДУРТАЙ ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ

Цуврал уулзалт

Сэдэв: Захиргааны байгууллагаас иргэний хувийн мэдээлэл ашиглах, боловсруулахтай холбоотой зарим асуудал

Панелист: Өмгөөллийн “Номин энд Адвокатс” ХХН-ийн партнер Б.Амарбат

2023.02.17 07.40 a.m. Чингис хааны музейн 1 давхарт, MUSE coffee shop




Цуврал №2: “Захиргааны байгууллагаас иргэний хувийн мэдээлэл ашиглах, боловсруулахтай холбоотой зарим асуудал”

Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооноос “Захиргааны байгууллагаас иргэний хувийн мэдээлэл ашиглах, боловсруулахтай холбоотой зарим асуудал” сэдэвт өглөөний уулзалтыг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Тус уулзалтын панелистаар Өмгөөллийн “Номин энд Адвокатс” ХХН-ийн партнер Б.Амарбат оролцсон. Мөн захиргааны эрх зүйн чиглэлээр ажиллаж буй хуульч, судлаач, эрх зүйч нар оролцож сонирхолтой яриа өрнүүлсэн.

Цуврал №3: “Миний дуртай захиргааны эрх зүй” чөлөөт сэдвийн хүрээнд захиргааны хэргийн шүүхийн түүх ба шилдэг хуульчдын эрэлд сэдэвт өглөөний уулзалт

Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооноос “Захиргааны хэргийн шүүхийн түүх ба шилдэг хуульчдын эрэлд” сэдэвт өглөөний уулзалтыг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан. Тус уулзалтын панелистаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Отгончимэг оролцов. Монгол Улсад захиргааны хэргийн шүүхийг үүсгэж хөгжүүлсэн түүхийг залуу хуульч, эрх зүйч, оюутнуудад эргэн сануулж, ирээдүйд захиргааны хэргийн шилдэг шүүгч болох хүсэл мөрөөдөлтэй хуульч нарт анхаарах асуудлуудын талаар үнэтэй зөвлөмжийг хэлсэн.

ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХОРОО
МИНИЙ ДУРТАЙ ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ
Цуврал уулзалт

Сэдэв: Захиргааны хэргийн шүүхийн түүх ба шилдэг хуульчдын эрэлд /шүүгчийн сонгон шалгаруулалт/

Панелист: Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Отгончимэг

2023.03.03 07:40 a.m. Чингис хааны музейн 1 давхарт, MUSE coffee shop




ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХОРОО
МИНИЙ ДУРТАЙ ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ
Цуврал уулзалт

Сэдэв: Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөлд төлөвлөлтийн эрх зүй хангагдсан уу?

Панелист: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн Т.Мөнх-Эрдэнэ

2023.03.10 Чингис хааны музей



Цуврал №4: “Миний дуртай захиргааны эрх зүй” чөлөөт сэдвийн хүрээнд “Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөлд төлөвлөлтийн эрх зүйн шаардлага хангагдсан уу” сэдэвт өглөөний уулзалт

Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооноос “Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөлд төлөвлөлтийн эрх зүйн шаардлага хангагдсан уу” сэдэвт өглөөний уулзалтыг 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгууллаа. Тус уулзалтын панелистаар Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүгч, Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн Т.Мөнх-Эрдэнэ оролцов. Мөн захиргааны эрх зүйн чиглэлээр ажиллаж буй хуульч, судлаач, эрх зүйч нар оролцож сонирхолтой яриа өрнүүлсэн. Цаг заваа зарцуулан Монголын хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Эрдэнэчимэг хуульчид хүрэлцэн ирж оролцсон.



ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХОРОО

Цуврал №5: “Миний дуртай захиргааны эрх зүй” чөлөөт сэдвийн хүрээнд “Шүүхийн хяналт: шүүхийн сахилгын хорооны шийдвэр” сэдэвт өглөөний уулзалт

“Миний дуртай захиргааны эрх зүй” цуврал хэлэлцүүлэг, уулзалтын ээлжит дугаар хэлэлцүүлгээр “Шүүхийн хяналт: Шүүхийн сахилгын хорооны шийдвэр” сэдвийн хүрээнд Шүүхийн сахилгын хорооны шинэ тутам хэрэгжиж буй үйл ажиллагаа, процессын тулгамдсан асуудлууд, шүүгчийн сахилгын зөрчлийг дүгнэж буй байдал болон практикт тулгарч буй бусад асуудлуудыг тойрч ярилцсан. Хэлэлцүүлэгт панелистаар хуульч, өмгөөлөгч Э.Энх-Эрдэнэ, Д.Отгонбат нар оролцсон.

ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХОРОО

МИНИЙ ДУРТАЙ ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ

Цуврал уулзалт



Панелист: Хуульч, өмгөөлөгч
Э.Энх-Эрдэнэ



Панелист: Хуульч, өмгөөлөгч
Д.Отгонбат

Сэдэв:
Шүүхийн хяналт:
Шүүхийн сахилгын
хорооны шийдвэр

2023 оны 03 сарын 24
өглөөний 07 цаг 40
Чингис хааны музейн 1
давхарт, MUSE coffee shop



ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХОРОО

МИНИЙ ДУРТАЙ ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ

Цуврал уулзалт



Сэдэв: Нийтийн ашиг
сонирхлыг төлөөлөн
нэхэмжлэл гаргах эрх

Панелист: Оч мүүдэл хуулийн
фирмын хуульч, өмгөөлөгч
Ө.Эрдэнэ-Очир



2023.05.19
07.40 а.м. Чингис хааны музейн 1
давхарт, MUSE coffee shop



Цуврал №6: “Миний дуртай захиргааны эрх зүй” чөлөөт сэдвийн хүрээнд “Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх” сэдэвт өглөөний уулзалт

“Миний дуртай захиргааны эрх зүй” цуврал хэлэлцүүлэг уулзалтын өнөөдрийн дугаар амжилттай боллоо. Өнөөдрийн хэлэлцүүлгээр “Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх” сэдвийн хүрээнд шүүхийн процессын тулгамдсан асуудлуудыг тойрч ярилцав. Хэлэлцүүлэгт панелистаар оролцсон хуульч, өмгөөлөгч Ө.Эрдэнэ-Очир оролцсон.

Цуврал №7: “Миний дуртай захиргааны эрх зүй” чөлөөт сэдвийн хүрээнд “Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн зохицуулалт” сэдэвт өглөөний уулзалт

“Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн зохицуулалт” сэдвийн хүрээнд шинэ тутам хөгжиж байгаа ойлголт, практикт тулгамдсан асуудлуудыг тойрч ярилцав. Хэлэлцүүлэгт панелистаар оролцсон хуульч, судлаач Р.Лхагвабаяр оролцсон.

ЗАХИРГААНЫ ЭРХ
ЗҮЙН ХОРОО

МИНИЙ ДУРТАЙ
ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ
Цуврал уулзалт

Сэдэв: Нийтийн эрх зүйн
хуулийн этгээдийн
зохицуулалт

Панелист: Хуульч Р.Лхагвабаяр

2023.05.26
07.40 а.м.

Чингис хааны музейн 1
давхарт, MUSE coffee shop



ХОЁРНИЙТИЙН УДИРДАГЫН ОНОЛ АРГА ЗҮЙ, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛЫГ ХАВСАРГАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Монгол Улсын Үндсэн хуулийн эрхийг баригч Б.Чимидийн нэрэмжит “Үндсэн хуулийн болон Захиргааны эрх зүйн суурь асуудал” олон улсын эрдэм шинжилгээний IV бага хурал 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр болсон. Тус бага хурлаар төрийн бүтэц, эрх мэдлийн хуваарилалт, Үндсэн хуулийн хяналт, хүний эрх, захиргааны эрх зүй, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, нийтийн өмчийн менежмент тэдгээрийн татвар ногдуулалт, уул уурхай ба газар ашиглалт, төрийн өмчит аж ахуйн нэгж, тэдгээрийн арилжааны асуудал мөн төрийн хариуцлага, сахилга бат зэрэг Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн өргөн хүрээний сэдвийн хүрээнд хуралдаж, хэлэлцэв.

Уг олон улсын эрдэм шинжилгээний хурлыг МУИС-ийн Хууль зүйн сургууль, Монголын Хуульчдын холбоо, Япон Улсын Нагояагийн их сургуулийн





ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХОРОО

Хууль зүйн сургууль, Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэц, Монгол Улсын Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Үндсэн хуулийн хүрээлэн, Нагояагийн их сургуулийн Азийн сателит кампус институт, Ханнс Зайделийн сан, Азийн сан, Чимид сан, Эрх зүйн судалгааны цахим өгөгдлийн сан Легалдата хамтран зохион байгуулсан. Хурлыг нэгдсэн болон салбар хуралдааны хүрээнд зохион байгуулсан бөгөөд Монгол, Япон, ХБНГУ, Канад, БНСУ, ОХУ, Унгар улсын нийт 23 илтгэгч англи, монгол хэл дээр илтгэл танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

Мөн хурлын үйл ажиллагааг Легалдата болон Монголын Хуульчдын холбооны цахим хуудсаар шууд дамжуулан олон нийтэд хүргэсэн. Захиргааны эрх зүйн хороог төлөөлөн тэргүүн Т.Мөнх-Эрдэнэ шүүгч оролцсон.



ГУРАВ. ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖЫН ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Легалдатагаас бэлтгэн хүргэдэг "legaltalk" подкастын энэ удаагийн дугаараар Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр баталсан Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон уг хуулийг дагалдуулан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн Т.Мөнх-Эрдэнэтэй ярилцсан.

Монголын Хуульчдын Холбооны Эдийн засгийн эрх зүйн хороо, Захиргааны эрх зүйн хороо, Хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хорооноос санаачлан Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгтэй хамтран "Нийгмийн даатгалын багц хуулиудын шинэчлэн найруулгын төсөл"-ийн хэлэлцүүлгийг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан.







ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХОРОО

ДӨРӨВ. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:

Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит шатрын тэмцээнд оролцсон.



Монголын Хуульчдын холбооны шилжин явах цом-2023 спортын 6 төрөлт тэмцээнд Захиргааны эрх зүйн хорооны гишүүд оролцсож эмэгтэй сагсан бөмбөгийн тэмцээнд 3-р байрт Б.Балжинням ахлагчтай Захиргааны эрх зүйн хороо, эмэгтэй волейболын тэмцээнд 3-р байрт С.Одмаа ахлагчтай Захиргааны эрх зүйн хороо, эрэгтэй волейболын тэмцээнд 3-р байрт А.Түвшинтөгс ахлагчтай Захиргааны эрх зүйн хороо тус тус байр эзэлж амжилт үзүүлсэн.



ХУУЛЬЧДЫН ТӨГӨЛД МОД ТАРИХ АЖИЛД ОРОЛЦСОН.

Монголын Хуульчдын холбооны захиргааны эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн дөрвөн гишүүнийг сонгох нөхөн сонгуулийг зохион байгуулсан. Санал өгөх үйл ажиллагаа 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 09:00 цагаас 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 18:00 цаг хүртэл явагдаж дууссан.



ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХОРОО

Монгол Улсын Их Хурлын Тамгын Газартай Хуульчдын холбоо хамран 2023 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд “Хуулийн төсөл боловсруулагчдын сургалт”-ыг зохион байгуулж анхны төгсөгчиддөө гэрчилгээ гардуулсан. Энэ үеэр Улсын Их Хурлын Тамгын газар, Хуульчдын Холбоо хууль тогтоох үйл ажиллагаанд хуульчдыг мэргэжлийн шинжээчээр оролцуулах, сургалт, судалгааны чиглэлээр хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулж Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Монголын Хуульчдын холбооны ерөнхийлөгч П.Одгэрэл нар гарын үсэг зурав.



Монголын хуульчдын холбооны Ерөнхийлөгч, доктор П.Одгэрэл, Тамгын газрын дарга Ш.Жолбарс нарыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Дуламсүрэн шүүгч нарын хамт хүлээн авч уулзав. Мөн тус уулзалтад тус шүүхийн шүүгч, Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн Т.Мөнх-Эрдэнэ байлцлаа.



Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн ээлжит хурлыг зохион байгуулж шинээр сонгогдсон Удирдах зөвлөлийн гишүүдийг танилцуулах, Байгаль орчны эрх зүйн дэд хорооны зохицуулагчийг батлах, Удирдах зөвлөлийн 1 гишүүний орон тоонд дахин сонгууль зарлах, хорооны нэгдүгээр улирлын ажлын тайлан сонсох, төсвийн зарцуулалтыг танилцуулах, Нээлттэй нийгэм форумаас ирүүлсэн саналыг хэлэлцэх, Хуульчдын холбооны Зөвлөлийн мэдээллийг сонсох, цаашид хорооны төлөвлөгөөт ажлуудыг идэвхжүүлэх зэрэг олон асуудлыг хэлэлцсэн.

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ДЭД ХОРОО

1. "СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ: ДОТУУР БАЙР" ҮНДЭСНИЙ II ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН.

Тус зөвлөгөөнөөр дотуур байрны хүүхдийн сурч боловсрох эрх, нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцсэн бөгөөд "Хүний эрх-дэвшилтэт бодлогын хүрээлэн"-ийн Гүйцэтгэх захирал, захиргааны эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн гишүүн Х.Баасанжаргал "Сурч боловсрох эрхийн линзээр дотуур байрыг тольдох нь" илтгэлээ танилцуулсан.

2. МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ ПЭЙЖ ХУУДСЫГ НЭЭЖ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЛҮҮДЭЭР ХАНГАЖ БАЙНА.

Пэйжид оруулсан мэдээллүүдээс дурдвал:



ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХОРОО

Монголын Хуульчдын холбооны цахим сонгуулийн системээр 2023 оны 01 дүгээр сарын 11-20-ны өдрийн хооронд Иргэний эрх зүйн гишүүдийн дунд явуулсан сонгуулийн дүнгээр олонхийн санал авсан Ч.Отгонбаатар, Т.Наранцогт, Б.Мөнхбат, Г.Давааням, В.Оюумаа, Э.Сугар-Эрдэнэ, О.Вандандорж, М.Ванчигмаа, С.Халиунаа, Б.Зол-Ундрах, Д.Түвшинтамир, Ц.Мөнхбат нарыг Иргэний эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн гишүүнээр, Г.Даваадоржийг хорооны тэргүүнээр сонгон батламжлав.

1 Хуульчийн мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагыг дээшлүүлэх, мэргэжлийн хариуцлагыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг блокчейн технологиор баталгаажуулах зорилгоор холбогдох байгууллагатай уулзалт зохион байгуулсан. Уулзалтад Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Иргэний эрх зүйн хорооны тэргүүн Г.Даваадорж, Монголын Хуульчдын холбооны ахлах мэргэжилтэн Х.Наранхүү, Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хороо хариуцсан мэргэжилэн Э.Сувд нар оролцсон бөгөөд уулзалтыг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн бүртгэл, баталгаажуулалт шинэ төвшинд гарч мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлын баталгааг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан. Дээрх ажил нь төслийн хүрээнд үргэлжилж байгаа болно.

2 “Шүүх эрх мэдлийн байгууллагуудын цахимжилт ба шинэчлэлт” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав.

Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооноос 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр “Шүүх эрх мэдлийн байгууллагуудын цахимжилт ба шинэчлэлт” сэдэвт хэлэлцүүлэгийг зохион байгуулав. Тус хэлэлцүүлэгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Шүүхүүд, Улсын Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн Ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар, Өмгөөлөгчдийн холбоо оролцсон бөгөөд зочин оролцогчоор Улсын бүртгэлийн ерөнхий газар, Германы олон улсын хамтын ажиллагаа GIZ, Европын холбооноос Монгол Улсад суугаа төлөөлөгчийн газар, АНУ-ын Элчин сайдын яам, Нээлттэй нийгэм форум, Азийн сан, Ханнс зайдаел сан оролцсон. Хэлэлцүүлгээр “Цагдаагийн байгууллагын цахимжуулалт ба цаашдын чиг хандлага” сэдвээр Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик мэдээллийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Жанчивдорж, “Прокурорын байгууллагын цахимжилт, бусад байгууллагын уялдаа” сэдвээр Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны дарга, ахлах прокурор Ц.Насанбат, “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарим хэргийг цахимжуулах нь” сэдвээр Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Одонтуул, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь цахимжилт, өнөөгийн нөхцөл байдал” сэдвээр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн дарга, хошууч Э.Итгэлтөгс, “Цахимжилт ба Хүний эрх” сэдвээр Өмгөөллийн “ЭмДиЭс энд ХаанЛекс” ХХН-ийн гишүүн, өмгөөлөгч Ж.Майзориг нар илтгэл хэлэлцүүлэн оролцлоо.

3. Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудал хэлэлцүүлгийг зохион байгуулав.

Монголын Хуульчдын Холбооны Иргэний эрх зүйн хороо нь “Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудал” хэлэлцүүлгийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хуульчдын танхимд зохион байгууллаа. Өмгөөллийн “Мөнхбат энд Нандин-Эрдэнэ” ХХК-ийн захирал өмгөөлөгч Ц.Мөнхбат “Шүүхийн харъяаллын маргаан, уламжлал, шинэчлэл”, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Хууль Эрх зүйн газрын хуульч, СБД-ийн Хөдөлмөрийн эрхийн маргааныг зохицуулах гурван талт хорооны гишүүн М.Саранцацрал “Хөдөлмөрийн эрхийн маргааныг зохицуулах гурван талт хорооны эрх зүйн зохицуулалт, түүний тулгамдсан асуудал”, “Анта энд Партнерс” хуулийн фирмийн партнер өмгөөлөгч М.Энхжин “Ажил, амралтын цагийн зохицуулалтын хэрэгжилт”, “Дуннаран энд Партнерс” ХХН-ийн ахлах хуульч, өмгөөлөгч Б.Шайрийбуу “Хөдөлмөрийн хуульд тулгарч буй асуудлууд ба хөдөлмөрийн сонирхолын маргаан” сэдвүүдээр тус тус илтгэл танилцууллаа. Хэлэлцүүлэгчээр Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Э.Энэбиш, Отгонтэнгэр их сургуулийн багш, өмгөөлөгч, докторант Б.Ургамалцэцэг нар оролцов. Хэлэлцүүлгээр Хөдөлмөрийн тухай хуулийн зарим асуудлуудын талаар хуульчид санаа бодлоо солилцож, хөдөлмөрийн эрхийн маргааныг зохицуулах гурван талт хороонд гарч буй тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, гурван талт хорооны маргаанд өмгөөлөгчийн оролцоог хангах талаар бодитой санал дэвшүүлж, ажил амралтын цаг, хөдөлмөрийн сонирхолын маргаан, хөдөлмөрийн арбитрч, зуучлагч нарын ёс зүйн дүрэм, бусад асуудлаар идэвхитэй санал солилцлоо. Хэлэлцүүлгийн үр дүнд Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудад саналаа холбогдох байгууллагад илэрхийлэх, зохион байгуулалтын шинжтэй асуудалд хуульчдын хувьд дэмжлэг буюу зохион байгуулалтын санал санаачлагыг дэмжин ажиллах зэрэг бодит санал, санаачлага үр дүнгүүд хэлэлцүүлгээс гарлаа. Тус хэлэлцүүлэгт нийт 128 хуульч, өмгөөлөгчид идэвхтэй оролцож санал бодлоо хуваалцав.





ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХОРОО

4. “Иргэний хуулийн хэрэглээг харьцуулсан эрх зүйн үүднээс” сэдвийн хүрээнд Иргэний хуулийг түүхчилсэн болон харьцуулсан эрх зүйгээр судлах хэрэгцээ шаардлага, Монгол Улсын хуульд туссан онолын зөрүүтэй зохицуулалт болон хэрэг маргаан хянан шийдвэрлэхэд гадаад улсын хууль тогтоомжийг хэрэглэх зорилгын хүрээнд подкаст хийж зочин хөтлөгчөөр “Өмгөөллийн Легал гайд” хуулийн фирмийн хуульч У.Азжаргал, зочноор Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавари муж улсын Регенсбург хотын сургуулийн төгсөгч, Монголын Хуульчдын холбооны сургагч багш Э.Нямбаатар нар оролцсон.



5. Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооноос санаачлан оюутнуудын дунд “Арилжааны хуулийн этгээдийн этгээдийн төрөл, хэлбэр, зохион байгуулалтын тулгамдсан асуудал” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Илтгэлийн уралдаанд “Өмгөөллийн Монгол Өмгөөлөгч” ххн-н Зөвлөх үйлчилгээний секторын ахлах өмгөөлөгч Б.Оюу, Зөвлөлийн гишүүн, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Э.Энэбиш, Иргэний эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, “Өмгөөллийн Легал Гайд” ХХН-ийн захирал Ч.Отгонбаатар нар шүүгчээр ажилласан бөгөөд тус хэлэлцүүлгээр 15 илтгэл нэгдүгээр шатанд ирсэнээс 9 илтгэл хоёрдугаар шатанд тэнцэн хэлэлцүүлэгдсэн.

Нэгдүгээр байранд МУИС-ийн ХЗС-ийн 5 дугаар курсын оюутан М.Амина, Г.Батзундуй нарын “Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн гишүүдэд ногдох ашиг хуваарилах болон хөрөнгө хуваарилах зохицуулалтын тулгамдаж буй асуудал” сэдэвт илтгэл, хоёрдугаар байранд МУИС-ийн ХЗС-ийн 5 дугаар курсын оюутан Р.Тэргэл “Нөхөрлөлийн гишүүдийн ашиг хуваарилах зохицуулалтын онцлог” сэдэвт илтгэл, гуравдугаар байранд МУИС-ын ХЗС-ийн Олон Улсын Эрх Зүйн ангийн 5-р курсын оюутан Б.Ариунзаяа “Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үндсэн шинж, статус, тэдгээрийн учир холбогдол” сэдэвт илтгэл шалгарсан бол тусгай байранд ИЗОУИС-ийн ХЗС-ийн 306-р бүлгийн оюутан Б.Ариунзул “Крипто бирж, түүний хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” сэдэвт илтгэлүүд шалгарсан байна.

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ХОРОО

1 Үндсэн хуулийн эрх зүйн хорооноос 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр “**Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт**” сэдэвт өглөөний уулзалтыг Хорооны тэргүүн Ш.Цогтоо удирдан нийт хуульчдын дунд нээлттэй зохион байгууллаа.

Монголын Хуульчдын холбоонд “Үндсэн хууль”-ийн төсөл болон “Зөвлөлдөх санал” асуулгын талаар хуульчид өөрсдийн болон хамт олныхоо байр суурийг идэвх санаачилгатай ирүүлж байгаатай холбогдуулан Үндсэн хуулийн эрх зүйн хорооноос хуульчдын дунд энэ сэдвээр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 30 гаруй хуульч харилцан санал солилцсон бөгөөд 02 дугаар сарын 6-наас 03 дугаар сар хүртэл Монголын Хуульчдын холбооны цахим сүлжээ болон веб сайт дээр нийт 10-н Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар хуульчдын постерууд тавигдсан.



2. Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран хүний эрхийн хэрэгжилттэй холбоотой богино хэмжээний видео контент хамтран хийх талаар тус Комиссын дарга Ж.Хунан, хорооны тэргүүн Ш.Цогтоо нар уулзалт хийлээ. Комиссын зүгээс Үндсэн хуулийн эрх зүйн хороотой хамтран ажиллах боломжтойг илтгэн мөн ХЭҮК-оос 2023 онд гаргах гэж буй хүний эрхийн нэр томъёоны номны ажлын хэсэгт орж хамтран ажиллахыг хүсэв.

Хуульчдын холбоо Монгол Улсын Засгийн газартай хамтран 2023 оны 05 дугаар сарын 02 ны өдөр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн хэлэлцүүлэг зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт төслийн танилцуулгыг ЗГХЭГ-ын дэд дарга бөгөөд Засгийн газрын хяналтыг хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар МУИС-ийн ХЗС-ийн профессор Хууль зүйн ухааны доктор Т.Мэндсайхан, Үндсэн хуулийн эрх зүйн хорооны тэргүүн, хууль зүйн ухааны доктор, Үндсэн хууль тогтоогч, гавъяат багш Ш.Цогтоо болон бусад хуульчид оролцож байр сууриа илэрхийллээ.



ШҮҮГЧДИЙН ХОРОО

НЭГ. Шүүгчдийн хорооны удирдах зөвлөлийн хурал зохион байгуулах

Шүүгчдийн хорооны удирдах зөвлөлийн хурлыг 2023.01.27, 2023.02.16, 2023.03.20-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан. Хорооны шинэ удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулж хорооны төлөвлөгөөг баталсан ба гишүүдийн хариуцан ажиллах хуваарийг гаргаж танилцуулсан. Тус хурлуудаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

- Хорооны 2023 оны төлөвлөгөө түүний өөрчлөлт
- Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчтэй хийх уулзалт
- Сайн дурын хороодын үйл ажиллагааны журмын танилцуулга
- Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит шатрын тэмцээн
- Хяналтын зөвлөлийн гишүүнд санал өгөх
- Нээлттэй нийгэм форумаас ирүүлсэн албан бичиг хэлэлцэх
- Чиг үүргийн хороолын гишүүнд нэр дэвшүүлэх үйл ажиллагааны тххай
- Хуульчдын холбооны шилжин явах цом -2023 тэмцээнийг зохион байгуулах гэх мэт асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.



ХОЁР. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн албан бичигт судалгааны сэдэв санал болгох:

Шүүгчдийн хорооны удирдах зөвлөлийн гишүүдээс санал авч саналыг нэгтгэн доорх сэдвүүдийг хүргүүлсэн. Үүнд:

Эрүүгийн сэдэв:

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл,
Залилан мэхлэх гэмт хэрэг,
Хүн худалдаалах гэмт хэрэг

Иргэний сэдэв:

Фидуци гэрээний маргаан,
Хөршийн эрхийн маргаан,
Өмчлөгчийн шаардах эрх,
Иргэний хуулийн 216 дугаар зүйлийн 216.4 дэх хэсгийн хэрэглээ,
Хүчин төгөлдөр бус хэлцэл,
Дампуурлын маргаан шийдвэрлэсэн шүүхийн практик.

Захиргааны сэдэв:

Захиргааны ерөнхий хууль дахь төлөвлөлтийн зохицуулалтыг хэрэглэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ,
Татварын нөхөн ногдуулалтын актад холбоотой маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ,
Захиргааны ерөнхий хууль дахь “хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим”-ыг хэрэглэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ,
Захиргааны ерөнхий хууль дахь мэдэгдэх, сонсгох ажиллагааны зарчмыг тайлбарлан хэрэглэсэн шүүхийн шийдвэрт хийх дүн шинжилгээ,
ЗХШХШТХ-ийн 106.3.5 эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоох, хүлээн зөвшөөрөх нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ.

ГУРАВ. Монголын Хуульчдын холбооны Тамгын газраас хороодын дунд зохион байгуулсан спорт тэмцээний үндсэн зохион байгуулагчаар Шүүгчдийн хороо ажиллав.

Монголын Хуульчдын холбооны “Шилжин явах цом-2023” спортын 6 төрөлт тэмцээнийг Монголын Хуульчдын холбоо, Шүүгчдийн хорооноос амжилттай зохион байгуулсан. Монголын Хуульчдын холбооны 10 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж байгаа спортын 6 төрөлт тэмцээнд Зөвлөл, Чиг үүргийн болон сайн дурын хороод, Тамгын газар, орон нутгийн салбарын гишүүдийн дунд 2023 оны 05 дугаар сарын 11,12,13,14-ний өдрүүдэд зохион байгуулагдаж нийт 450 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорьж өрсөлдсөн. Тэмцээний нээлт, хаалтын ёслолын ажиллагаанд Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, ШЕЗ-ийн гишүүн З.Зоригтбаатар, Н.Баасанжав, А.Насандэлгэр, Улсын Ерөнхий Прокурорын орлогч, Хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Б.Дашдаваа, Монголын Нотариатчидын танхимын Ерөнхийлөгч Ч.Баянжаргал, МХХ-ны Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хуульч Д.Батсүх, Б.Гүнбилэг, Б.Өнөмөнх, гавьяат багш, МУИС-ийн хууль зүйн сургуулийн багш доктор, профессор Т.Мэндсайхан, Үндсэн Хуулийн эрх зүйн хорооны тэргүүн Ш.Цогтоо, Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн Т.Мөнх-Эрдэнэ, Иргэний эрх зүйн хорооны тэргүүн Г.Даваадорж, Өмгөөлөгчдийн хорооны тэргүүн Э.Ганхөлөг, Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны дарга Б.Өнөрмаа, Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих асуудал эрхэлсэн хорооны тэргүүн Б.Түмэнжаргал, Хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооны дарга Ш.Алтангадас, Хууль зүйн шинжлэх ухаан боловсролын хөгжлийг дэмжих хорооны дарга Ц.Мөнхбат, Эдийн засгийн эрх зүйн хорооны тэргүүн Б.Баасандорж, Олон улсын эрх зүйн хорооны тэргүүн Х.Наранбулаг, Өмгөөллийн нөхөрлөлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооны тэргүүн Д.Түвшинтамир, нар оролцож, баг тамирчдад амжилт хүссэн. Мөн тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагчаар Шүүгчдийн хорооны удирдах зөвлөлийн гишүүд ажилласан.



ШҮҮГЧДИЙН ХОРОО

Багийн нийлбэр дүнгээр:

- 1-р байр Э.Ганхөлөг ахлагчтай
Өмгөөлөгчдийн хороо
- 2-р байр Ж.Болорпүрэв ахлагчтай
Прокурорын хороо
- 3-р байр С.Энхбаяр ахлагчтай
Шүүгчдийн хороо тус тус шалгарсан.



Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит шатрын тэмцээнд оролцов.

Монголын Хуульчдын холбооны ерөнхийлөгчийн нэрэмжит шатрын тэмцээнд Шүүгчдийн хорооноос идэвхтэй оролцож нийлбэр оноогоор 4-р байрт шүүгч н.Энхжаргал шилдэг тоглогчоор шалгарсан.



Хуульчдын төгөл мод тарих ажиллагаанд оролцсон. Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн гишүүд идэвхтэй оролцсон.



ПРОКУРОРЫН ХОРОО

НЭГ. Прокурорын хууль ёсны эрх, эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд:

Монголын Хуульчдын холбооны Прокурорын хороо нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох дүрэмд заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ холбооноос дэвшүүлсэн зорилт, баримталж буй бодлого, 2023 оны төлөвлөгөөний биелэлтийг хангах, хуульчдын хууль ёсны эрх, эрх ашгийг хамгаалах, иргэдэд ил тод нээлттэй байх, хууль тогтоомж, эрх зүйн бусад баримт бичгийг боловсонгүй болгоход чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд хорооны удирдах зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулж хорооны тэргүүн болон 11 гишүүний бүрэлдэхүүнтэй ажилласан. 2023 оны эхний хагас жилийн байдлаар тус хороонд нийт 607 прокурор, бусад 22 буюу нийт 629 гишүүнчлэлтэй хуульчид байна.

Дээрх хугацаанд хуульчдын холбоо болон прокурорын хорооны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг зохион байгуулахаас гадна гадаад улсын эрх бүхий байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран прокуроруудын чадавхыг нэмэгдүүлэх сургалтад оролцуулах, хурал, зөвлөгөөн зохион байгуулах зэргээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

ХОЁР. Зохион байгуулалтын ажлын хүрээнд:

Монголын Хуульчдын холбооны прокурорын хорооны Удирдах зөвлөлийг хуралдуулж 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хэлэлцэн баталсан. Хорооны 2023 оны үйл ажиллагааны 4 зорилтын хүрээнд нийт 13 ажил, арга хэмжээг зохион байгуулахаар тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Монголын Хуульчдын холбооны Зөвлөлд Прокурорын хорооны удирдах зөвлөлийн гишүүд болон прокуроруудын төлөөлөл багтдаг бөгөөд зөвлөлийн үйл ажиллагаанд тогтмол оролцож, холбоо, хорооны үйл ажиллагааг уялдуулан хамтран ажилласан байна.

Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулж буй эрдэм шинжилгээний хурал, арга хэмжээнд хорооны гишүүдийн төлөөлөл тогтмол оролцож ирснээс гадна хуульч нарт зориулан явуулдаг хуульчийн үргэлжилсэн сургалтуудад Прокурорын хорооны гишүүдээс хичээл заасан байна.

Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооноос “Шүүх эрх мэдлийн байгууллагуудын цахимжилт ба шинэчлэлт” хэлэлцүүлгийг 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан бөгөөд энэхүү хэлэлцүүлэгт “Прокурорын байгууллагын цахимжилт, бусад байгууллагын уялдаа” сэдвээр Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны дарга, ахлах прокурор Ц.Насанбат итгэл хэлэлцүүлж оролцсон.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан хуульчидтай уулзах уулзалтад Прокурорын хорооны удирдах зөвлөлийн гишүүдийн төлөөлөл оролцсон.

Монголын Хуульчдын холбооноос жил бүр уламжлал болгон 05 дугаар сарын 01-ний өдөр “Хуульчийн Пробоно-2023” өдөрлөгийг зохион байгуулах ажлын хүрээнд Прокурорын хорооноос Аймаг, Нийслэл, Тээвэр, Дүүргийн прокурорын газруудад тодорхой үүрэг, чиглэлийг өгч, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Тус өдөрлөгийн үеэр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой иргэдийн гомдол, хүсэлтийг хүлээн авч, прокурорын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийн



ПРОКУРОРЫН ХОРОО

талаар болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн 18 төрлийн 700 гаруй брошюр, гарын авлага, сэтгүүлийг тарааж, видео шторкуудыг олон нийтэд хүргэсэн.

Мөн Аймаг, Нийслэлийн ерөнхий боловсролын нийт 20 сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад “Нууцтай байх эрх” сэдвээр тус хорооны гишүүд сургалт зохион байгуулсан.

Прокурорын хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Хуульчдын холбооны бүртгэлд прокурорын хорооны гишүүдийн бүртгэл, мэдээллийг тулгах, шинэчлэх ажлыг зохион байгуулах”-аар тусгасны дагуу нийт 607 прокуроруудын болон хуульчийн гэрчилгээтэй 22 туслах ажилтнуудын холбогдох мэдээллийг нэгтгэн 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 2/43 дугаартай албан бичгээр Монголын Хуульчдын холбооны Тамгын газарт хүргүүлж, бүртгэлийг шинэчлүүлсэн.

Хуульчдын дунд спортын уралдаан, тэмцээнийг зохион байгуулах ажлын хүрээнд Монголын Хуульчдын холбооны зөвлөл, чиг үүргийн болон сайн дурын хороод, Тамгын газар, орон нутгийн салбарын гишүүдийн дунд 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 14-ний өдрүүдэд зохион байгуулсан спортын тэмцээнд тус хорооноос амжилттай оролцсон. Прокурорын хорооны гишүүд нь тэмцээний дартс, боулинг, биллиард, ширээний теннис, волейбол, сагсан бөмбөг гэсэн тэмцээний 6 төрлүүдэд оролцож, амжилт үзүүлсэн байна.

Түүнчлэн, Төв, орон нутгийн прокурорын газруудын дунд 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 10-ны өдрүүдэд “Спортын бага наадам-2023” тэмцээнийг зохион байгуулж, Улсын Ерөнхий прокурорын газар, Нийслэл, Тээвэр, Дүүргийн прокурорын газар, Ахмадын холбооны баг, тамирчид нэг бүс болж Улаанбаатар хотод, орон нутгийн прокурорын газруудын баг,

тамирчид 5 бүсэд хуваагдан оролцлоо. Тэмцээнийг сагсан бөмбөг, гар бөмбөг, снукер бильярд, ширээний теннис, дартс, шатар, даам, усан сэлэлт гэсэн 8 төрлөөр зохион байгуулсан бөгөөд тэмцээний төрөл тус бүрт I, II, III байр шалгаруулж, багийн дүнг төрөл тус бүрт нэгтгэж, нийлбэр дүнгээр 1-3 байр эзлүүлэн шалгаруулав.

Улсын ерөнхий прокурорын газрын дэргэд Сургалт, судалгааны хүрээлэн байгуулагдсаны 50 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд Тус хүрээлэнгээс санаачлан, Монголын Хуульчдын холбоо, түүний дотор Прокурорын хороо, Эрүүгийн эрх зүйн хороон, Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролыг дэмжих хороотой хамтран “Мөнгө угаах гэмт хэрэг: онол, практикийн асуудал” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг хоёр үе шаттай зохион байгуулсан. Энэ арга хэмжээ мөнгө угаах гэмт хэргийн талаарх ойлголт, чиг хандлагыг оюутан суралцагчдад мэдээлэн хүргэх, их, дээд сургуулийн оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх сонирхол, санаачилгыг дэмжих, илтгэх ур чадвар, арга барилыг төлөвшүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, дүгнэлт, саналыг холбогдох байгууллагуудад уламжлах зорилгоор зохион байгуулагдсан. Эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн их сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль, Шихихутуг их сургууль, Их засаг олон улсын их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Орхон их сургууль, Олон Улсын Улаанбаатар их сургуулийн оюутан, сонсогчдоос нийт 47 илтгэл ирүүлсэн бөгөөд хоёрдугаар шатанд 10 илтгэлийг сонгон шалгаруулж хэлэлцүүлсэн. Илтгэлийн хэлэлцүүлгийг 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж, шилдэг илтгэгч нарыг шалгаруулж, шагналын арга хэмжээг зохион байгуулсан нь эрдэм шинжилгээний чухал арга хэмжээ болсон. Уг арга хэмжээний зардал санхүүжилтийг Монголын хуульчдын холбооноос шийдвэрлэж өгсөн. Энэ талаарх мэдээллийг Улсын ерөнхий прокурорын газар болон Монголын Хуульчдын холбооны цахим хуудсаар олон нийтэд түгээсэн.

Монголын Хуульчдын холбооноос 2023 оны 03 дугаар сарын 01-нээс 07 дугаар

сарын 01-ний өдөр хүртэл хэрэгжүүлсэн “Менторшип-2023” хөтөлбөрийн ментороор Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн судалгааны албаны дарга, ахлах прокурор, доктор, дэд профессор Б.Мөнхдорж, хяналтын прокурор, доктор Ц.Мөнхбат, Б.Өнөрмаа нар сонгогдон ажилласан ба тус бүр 3 менти хуульч нартай батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зөвлөгөө өгч, хамтран ажилласан байна.

Азийн сан, Монголын Хуульчдын Холбоотой хамтран 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан “Сургагч багшийн сургалт”-д 60 сургагч багшид Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Судалгааны албаны хяналтын прокурор Б.Өнөрмаа нь “Сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй” сэдвээр хичээл заасан. Тус сургалтад ахлах прокурор Ц.Насанбат, Б.Мөнхдорж, хяналтын прокурор Ц.Мөнхбат, Я.Мөнхзаяа нар сургалтад хамрагдан сургагч багшийн гэрчилгээ авсан.

Олон нийттэй харилцах ажлын чиглэлээр:

Прокурорын байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэхдээ радио, телевиз, сонин зэрэг уламжлалт сувгуудыг ашиглахаас гадна нийгмийн бусад шинэ сүлжээ, видео танилцуулга, анимейшн зэргийг ашиглан хүргэж ажилласан байна. Үүнд, Монголын Хуульчдын холбоо, Прокурор хороотой хамтран ажилласан. 2023 оны эхний хагас жилийн “Улсын Ерөнхий прокурорын газар Олон нийттэй харилцах алба” гэсэн нэртэй фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан 7 хоногт 20-25 мэдээ, мэдээлэл, контент бэлтгэн олон нийтэд хүргэж 17.000 орчим дагагчтай байсан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар 7 хоногт 25-30 мэдээ, мэдээлэл, контентыг бэлтгэн олон нийтэд хүргэж 21.600 орчим дагагчтай болсон.

Өнгөрсөн 2021 онд “Улсын Ерөнхий Прокурорын газар ОНХА” Youtube сувагт 88 видео, контент, “УЕПГ-ын Олон нийттэй харилцах алба” M-Plus платформд 16 подкаст, “УЕПГ-ын Олон нийттэй харилцах алба” твиттер хаягт 428 мэдээ, мэдээлэл, “Prokurormn” инстеграмд 265 орчим мэдээ, мэдээлэл нийтлэж олон нийтэд хүргэж байсан бол 2023 оны эхний хагас жилд Youtube сувагт 111 видео, M-Plus платформд 18 дугаар подкаст, твиттерт 384 мэдээ, мэдээлэл, инстеграмд 366 мэдээ, мэдээлэл нийтлэн, олон нийтэд хүргэсэн мэдээ, мэдээлэл өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн хүсэлтийг эх сурвалжаас нь тодруулан, тухай бүр мэдээлэл өгч ажилласан байна. Тайлангийн хугацаанд нийт сэтгүүлчдийн 107 хүсэлтийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 78.3 хувиар өсжээ.

Мөн Монголын хуульчдын холбоотой хамтран Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Бид хуульч эмэгтэйчүүд” 13 минутын нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэсэн.

Долоо хоног бүр бэлтгэн олон нийтэд хүргэдэг “Pro podcast”-ын агуулга, өнгө төрхийг шинэчлэн, энгийн, ойлгомжтой байхад анхаарч, улирал тутамд өөр өөр сэдвээр мэдээллүүдийг хүргэх, подкастыг дүрсжүүлэх зэрэг арга хэмжээг авсан. 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн “Про подкаст”-ын агуулга, өнгө төрхийг шинэчлэн, энгийн, ойлгомжтой байхад анхаарч, подкастыг дүрсжүүлэх арга хэмжээг авч, нийт 14 дугаарыг гаргасан.

Түүнчлэн, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр видео контент 124, зурган poster 134 хийж байгууллагын сайт болон олон нийтийн сүлжээнд байршуулсан. Байгууллагын хэмжээнд зохион байгуулсан нийт 79 ажил, арга хэмжээний үеэр 12.344 фото зураг, дүрс авч, архив үүсгэн хадгалж ажилласан байна.



ПРОКУРОРЫН ХОРОО

ГУРАВ. Прокурорын хууль ёсны эрх, эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд:

Байгууллагын соёл, ажилтнуудын сэтгэл ханамж, хүний нөөцийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг "HR consulting" ХХК-аас Монгол Улсын ерөнхий прокурорын газрын захиалгаар хийсэн Байгууллагын соёл, сэтгэл ханамжийн судалгааны тайланг 2023 оны 05 дугаар сард нэгж прокурорын газруудад хүргүүлж, Прокурорын хорооны нийт гишүүдэд танилцуулж, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсан байна.

ДӨРӨВ. Хууль тогтоомж, эрх зүйн бусад эрх зүйн акт, баримт бичгийг боловсронгуй болгох ажлын хүрээнд:

Монголын Хуульчдын холбоонд эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудаас ирүүлсэн хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, эрх зүйн бусад акт, баримт бичгийн төсөл боловсруулахад оролцох ажлын хүрээнд тус холбооноос тухай бүр ирүүлсэн санал авах тухай албан бичгийн дагуу холбогдох газар, хэлтсүүдэд хүргүүлэн, өгсөн саналыг нэгтгэн хариу хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.

Тухайлбал, прокурорын хорооноос 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 9/1820 дугаартай албан бичгээр "Хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх журам"-ын төсөлд санал боловсруулж хүргүүлсэн.

Мөн 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 1/3389 дугаартай албан бичгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.13 дугаар зүйлийн 1, 39.10 дугаар зүйлийн 4, 40.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг зөв хэрэглэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах үүднээс тайлбар гаргахтай холбоотой холбогдох саналыг хүргүүлжээ.

Прокурорын хорооны зарим гишүүдийн зүгээс Монголын Хуульчдын холбооны үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулахад ажилласан байна. Тухайлбал, прокурор, доктор Б.Өнөрмаа Монголын Хуульчдын холбооны "Хуульчийн үргэлжилсэн багц цаг

тооцох журам", "Албан бус сургалт явуулах журам"-ыг шинээр боловсруулах ажлын хэсгийг ахлан, батлуулсан байна.

ТАВ. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд:

Тайлангийн хугацаанд прокурорын хорооны гишүүдийг гадаадулсад туршлага судлуулах, олон улсын хурал, зөвлөгөөн, семинар, сургалтад тус хорооны гишүүдийг хамруулж мэргэжлийн чадавхийг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр Итали, АНУ, Япон, Гүрж, БНКУ, БНСУ, Бүгд Найрамдах Сингапур улс, ОХУ, БНХАУ, БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс ХонгКонг тус бүр 1, Тайландын Хаант Улсад нийт 3, бүгд 13 удаагийн сургалт, олон улсын хурал, зөвлөгөөн зэрэг гадаад арга хэмжээнд 47 прокурорыг оролцуулж, зорилтын хэрэгжилтийг хангасан. Зарим сургалт, бусад арга хэмжээг дурдвал:

- 2023 оны 02 дугаар сард Итали улсад зохион байгуулагдсан "Хөрөнгийг мөшгөх, буцаан авах тогтолцоог хөгжүүлэх форум" сэдэвт сургалт;
- 2023 оны 03 дугаар сард Тайландын Хаант Улсын Бангкок хотод зохион байгуулагдсан "Дижитал нотлох баримтын тухай" сэдэвт сургалт;
- 2023 оны 03 дугаар сард АНУ-д зохион байгуулагдсан Олон улсын манлайллын албатай хамтран "АНУ-ын хууль, эрх зүйн тогтолцоо, шүүх, прокурорын байгууллагын онцлог, чиг үүрэг"-ийн талаарх танилцуулга сургалт;
- 2023 оны 03 дугаар сард Гүрж улсын Тбилиси хотод зохион байгуулагдсан "Хууль сахиулах байгууллагын эмэгтэй албан хаагчдын манлайлал, мансууруулах бодис, хар тамхитай холбоотой гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны сэдэвт сургалт;
- 2023 оны 04 дүгээр сард Тайландын Хаант Улсын Бангкок хотод зохион байгуулагдсан Байгалийн баялгийн эсрэг гэмт хэргийг мөрөн шалгах ажиллагаа сэдэвт Олон Улсын Хууль сахиулах Академи /ILEA/-ийн сургалт;
- 2023 оны 04 дүгээр сард БНСУ-д зохион байгуулагдсан Зүүн өмнөд

Азийн орнуудын гадаад хамтын ажиллагааны сүлжээ /SEAJust network/-ний “Хулгайлагдсан хөрөнгийг эргүүлэн авах, олон улсын хамтын ажиллагааны шинж, чиг хандлага сэдэвт” сургалт;

- 2023 оны 05 дугаар сард БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс ХонгКонгд зохион байгуулсан “Цахим гэмт хэргийн мөрдөн шалгах болон яллах ажиллагаа: Шүүх хуралдааны мэтгэлцээн”;
- 2023 оны 05 дугаар сард Тайландын Хаант Улсын Бангкок хотод зохион байгуулагдсан “Хөрөнгө буцаах, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа” сэдэвт Олон улсын хууль сахиулах академийн сургалт;
- 2023 оны 06 дугаар сард Бүгд Найрамдах Сингапур Улсад эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, авлигатай тэмцэх болон хөрөнгө буцаах чиглэлээр сайн туршлага судлах сургалт зэрэг болно.



ПРОКУРОРЫН ХОРОО

1 Иргэдийн эрх зүйн ухамсар, соёлыг төлөвшүүлэх, хөгжүүлэх зорилгоор олон нийт болон нийгмийн эмзэг хэсэгт хууль тогтоомжийг бүхий л хэлбэрээр сурталчлан таниулах:

Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн тушаалаар жил бүрийн тавдугаар сарын 01-ний өдрийг “Хуульчийн про боно өдөр” болгон зарлаж, Монгол орон даяар тэмдэглэн өнгөрүүлээ.

САНААЧЛАН ЗОХИОНБАЙГУУЛАГЧ: ХАМТРАН ОРЛОДГОЧ БАЙГУУЛЛАА:

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО

“ХУУЛЬЧИЙН ПРО БОНО ӨДӨР-2023”

2023.05.01

НИЙСЛЭЛ БОЛОН 21 АЙМГИЙН ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ӨГӨХ ӨДӨРЛӨГ БОЛНО

Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчид тус өдөр 75050801, 75050802, 75050803, 75050804 дугаарын утсаар иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг үнэ төлбөргүй өгнө.

Иргэн Та 2023 оны тавдугаар сарын 01-ний өдрийн 10:00-17:00 цагийн хооронд Д.Сүхбаатарын талбайд хүрэлцэн ирж хууль, эрх зүйн зөвлөгөө мэдээллийг үнэ төлбөргүй аваарай.

Улаанбаатар хот болон 21 аймагт “Хуульчийн про боно өдөр-2023” өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчдаас гадна Хууль зүй, дотоод хэргийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн засаг даргын Тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Нотариатчдын танхим, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Архивийн ерөнхий газар, Хууль зүйн туслалцааны төв, Санхүүгийн зохицуулах хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хил хязгааргүй хуульчид ТББ, Легал Легаси, Эм Жэй Эл Атторнейс зэрэг өмгөөллийн нөхөрлөлүүд оролцон үйл ажиллагаагаа танилцуулж, төрийн зарим үйлчилгээг үзүүлснээс гадна **3200** гаруй иргэнд хууль зүйн болон төрийн зарим үйлчилгээний талаар зөвлөгөө, мэдээлэл мөн Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчид 75050801, 75050802, 75050803, 75050804 дугаарын утсаар **100** орчим иргэнд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг үнэ төлбөргүй өгч ажилласан байна.



ХУУЛЬЧИЙН НИЙТЭД ТУСТАЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ХОРОО

2. Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудад “Нууцтай байх эрх” сэдвээр сургалт зохион байгуулах ажлын хүрээнд:

Хүний эрхийн үндэсний хуульч, өмгөөлөгч болон прокурор хамтран сургалт орсон комисстой хамтран 2023 оны 04 сарын 27-ны өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд “Нууцтай байх эрх” сэдвийн хүрээнд улсын хэмжээнд нийт **65** сургуулийн **6883** сурагчдад сургалт орлоо.



3. Хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудын дунд илтгэлийн уралдаан зарлаж, дүгнэх:

“Хуульчийн про боно өдөр-2023” арга хэмжээний хүрээнд Монголын хуульчдын холбооны Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хорооноос хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудын дунд **“Пробоно-Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын онцлог, тулгамдаж буй асуудал”** сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг зохион байгуулсан бөгөөд нийт 10 илтгэл ирсэн бөгөөд шилдгээр шалгарсан оюутнуудын

шагналыг нээлтийн арга хэмжээний үеэр гардууллаа. Нэгдүгээр байранд МУИС-н Хууль зүйн сургуулийн IV түвшний оюутан Е.Гүлбану “Шүүхээр хамгаалуулах стратегийн өмгөөлөл ба захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалт” сэдэвт илтгэл, Хоёрдугаар байранд ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн 221-р дамжааны оюутан М.Энхням, Н.Эрдэнэтуяа нарын “Про боно буюу хуульчийн нийтэд тустай үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт ба онол практикийн асуудал харьцуулсан судалгаа” сэдэвт илтгэл, Гуравдугаар байранд МУИС-ын хууль зүйн сургуулийн IV түвшний оюутан Л.Энхсайханы “Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг санхүүжилт ба татварын системийг боловсронгуй болгох замаар сайжруулах нь” сэдэвт илтгэл, Тусгай байранд



МУИС-ын хууль зүйн сургуулийн IV түвшний оюутан Э.Минжиний “Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох нь” сэдэвт илтгэл мөн Шихихутуг их сургуулийн III түвшний оюутан Т.Түвшинжаргалын “Пробоно-Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд нийтийн эрх ашгийг төлөөлөн өмгөөлөгч нэхэмжлэл гаргах нь” сэдэвт илтгэлүүд шалгарлаа.



ХУУЛЬЧИЙН НИЙТЭД ТУСТАЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ХОРОО

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
МОНГОЛЫН ХУУЛЦЫН ХОЛБОО

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ӨДӨРЛӨГ

Иргэн та 2023.04.19-ний өдөр
09:00-17:00 цагийн хооронд

75050801 75050803
75050802 75050804

ДУГААРУУДАД ХОЛБОГДОЖ МӨН
НИЙСЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН
ТӨВҮҮДЭЭС ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АНХАН
ШАТНЫ ЗӨВЛӨГӨӨГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ
АВААРАЙ

Бүх нийтийн эрх зүйн
боловсролыг дээшлүүлэх
үндэсний хөтөлбөр



Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Нийслэлийн иргэдийн хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үйл ажиллагааны хүрээнд сар бүрийн 3 дахь долоо хоногийн лхагва гарагт иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй өгөх өдөрлөгийг тогтмол зохион байгуулдаг.

Энэ хүрээнд Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв (Драгон, Мишээл, Дүнжингарав, Зургаан буудал-оргил, Баянхошуу, Хорооллын эцэс Е-март)-д болон 75050801, 75050802, 75050803, 75050804 дугаарын утсаар иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг үнэ төлбөргүй өгсөн бөгөөд 2023 оны 06 дугаар сарын байдлаар нийт **435** иргэнд зөвлөгөө өгсөн.

4. Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг түгээн таниулах ажлын хүрээнд:

Олон улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн сургуулийн төгсөх курсын оюутнуудад “**Про боно хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, онцлог зорилт**” сэдэвт сургалтыг 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Г.Бат-Отгон зааж тус сургуулийн 80 орчим оюутан хамрагдлаа.

ХУУЛЬЧИЙН НИЙТЭД ТУСТАЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ХОРОО

5. ШШГЕГ-ын харьяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж буй өсвөр насны хүүхдүүдийн хичээлийн болон хүмүүжиж буй байрны нөхцөлийг сайжруулах, хүмүүжигч өсвөр насны хүүхдүүдийн сурах эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах стратегийн өмгөөлөл хийх ажлын хүрээнд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын нээлттэй хаалганы өдөрлөгт хорооны гишүүд болон хуульч О.Чулуунцэцэг, Г.Оюунболд нар хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө мэдэлээл өгч ажиллаа.



6. Бусад

Монголын Хуульчдын холбооны “Шилжин явах цом-2023” спортын 6 төрөлт тэмцээнд Хуульчийн нийтэд тусгай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хорооноос амжилттай оролцон Дартсийн төрөлд мөнгөн медал авч амжилттай оролцлоо.



ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА, ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хорооны Удирдах зөвлөлийн хурлыг 2023 оны 01 сарын 27, 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулав.


1 Төлбөрийн чадваргүй иргэдээс хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх:

2023 оны 06 дугаар сарын байдлаар нийт төлбөрийн чадваргүй 30 иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн. Үүнд:

- Иргэний хэрэг 16
- Эрүүгийн хэрэг 6
- Захиргааны хэрэг 5
- Зөрчлийн хэрэг 3

2 Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хууль эрх зүйн сургалт зохион байгуулах:

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр”, Монголын Хуульчдын холбооны Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал хариуцсан хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд сэтгүүлчдийн эрх зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, сэтгүүлчдээр дамжуулан олон нийтэд хууль, эрх зүйн мэдлэг ойлголт болон бусад мэдээ мэдээллийг хүний эрхэд суурилсан хандлагаар, хуульд нийцсэн, үнэн зөв хүргэхэд энэхүү сургалтын зорилгоор **“Сэтгүүлчдийн эрх зүйн боловсрол”** сургалтыг Монголын хуульчдын холбоо, Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хорооноос 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгууллаа.



Уг сургалтад Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн гишүүн 50 сэтгүүлч оролцож, эрх зүйн онолын үндсэн асуудал, хууль ба шударга ёс, хүний эрх ба хүний эрхийн зөрчил, Үндсэн хууль ба үндсэн хуулийн процесс, захиргааны эрх зүйн ойлголт, захиргааны хэргийн онцлог, эрүүгийн эрх зүйн ерөнхий ойлголт, гэмт хэрэг ба зөрчил, Монголын Хуульчдын холбооны Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хорооны үйл ажиллагаа, Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа зэрэг сэдвүүдээр нийт 4 цагийн мэдээлэл авсан.

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА, ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО



Цаашид энэ төрлийн сургалт зохион байгуулахад ямар асуудалд анхаарах шаардлагатай вэ гэдэг нээлттэй асуултанд оролцогчид маш идэвхитэй хариултыг өргөн хүрээнд өгсөнөөс дурдвал:

- Сургалтын цагийг анхаарах
- Цаашид гүнзгийрүүлэн сурах
- Онол практикийг хослуулах
- Бодит жишээ баримт дээр ярилцах
- Гарын авлага, тараах материал өгөх
- Багш нартай эргэн холбогдох боломжийг бүрдүүлэх
- Сургалтыг цагт нь эхлүүлэх, бусад оролцогч нартаа саад болохгүй байхыг урьдчилан сануулах зэрэг дэг тогтоох
- Сэдэв сэдвээр нь дэлгэрэнгүй заалгах хүсэлтэй байгаа гэсэн байна.

Цаашид энэ төрлийн сургалтаас ямар сэдвээр дахин сургалт авахыг хүсэж байгааг тодруулах нээлттэй асуултанд оролцогчид 20 гаруй илүү нарийвчилсан сэдвүүдийг нэрлэж заасан нь сургалтанд оролцогчид хууль, эрх зүйн мэдлэг ойлголт авах эрмэлзлэл өндөр байгааг харуулж байна. Сургалтанд хамрагдсан 43 сэтгүүлчид сертификат гардуулав.





ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫГ ДЭМЖИХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Монголын Хуульчдын Холбооны Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих асуудал эрхэлсэн хороо нь “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 49 дүгээр зүйлийн 49.4, 49.13 дахь заалт, “Хуульчдын холбооны дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.9, 8.10 дугаар заалтыг үндэслэн, Монголын Хуульчдын Холбооны Зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 38 дугаар тогтоолоор батламжлагдсан.

Тус хороо нь нийт 170 гишүүнтэй бөгөөд 2023 оны 03 дугаар сараас хорооны тэргүүнээр өмгөөлөгч Д.Түмэнжаргал сонгогдон, Удирдах зөвлөлийн 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Шинээр сонгогдсон тэргүүн болон удирдах зөвлөлийн гишүүд 2023 оны төлөвлөгөөг 04 дүгээр сард дахин баталж тодорхой хэд хэдэн зорилтот ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд эхний хагас жилийн байдлаар доор дурдсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Хорооны үйл ажиллагааг сурталчлах, олон нийтэд таниулах ажлын хүрээнд цахим хаяг нээж нийтэд мэдээллийг цаг алдалгүй хүргэж байна.
- Монголын Хуульчдын холбооноос “хуульчдын төгөлтэй болцгооё” гэсэн уриалгын хүрээнд Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих асуудал эрхэлсэн хорооны гишүүд идэвхитэй оролцсон.



ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН ХОРОО

Эдийн засгийн эрх зүйн хороо нь 2023 оны Монголын Хуульчдын холбооны ерөнхий төлөвлөгөө, Эдийн засгийн эрх зүйн хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө болон холбогдох бусад дүрэм, журамд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

НЭГ. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Монголын Хуульчдын холбооны Эдийн засгийн эрх зүйн хорооны сонгууль нь 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс 01 дүгээр сарын 20-ны өдөр Монголын Хуульчдын холбооны www.mglbar.mn цахим хуудасны сонгуулийн системээр явагдаж Эдийн засгийн эрх зүйн хорооны тэргүүнээр хуульч Б.Баасандорж сонгогдов.

Мөн хорооны Удирдах зөвлөлийг сонгох сонгуульд хамгийн их санал авсан хуульч Д.Ганхүрэл, Ц.Маргад-Эрдэнэ, Б.Баяраа, Т.Жавхлантөгс, Г.Нямсүрэн, Ц.Амартүвшин, Г.Эсэн, Б.Төрбат, Н.Баярчимэг, Х.Тэмүүжин, Д.Хулан, Н.Энхцэцэг нар удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Удирдах зөвлөлийн шинэ бүрэлдэхүүн 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр хуралдаж, Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Ахлах мэргэжилтэн Ж.Бариаширсүрэн нартай уулзлаа. Тус хурлаар Сайн дурын хорооны зохион байгуулалттай холбоотой нийтлэг журмын танилцуулгыг хороо хариуцсан мэргэжилтэн П.Отгонцэцэг танилцуулав.




ХОЁР. “LAW AND ECONOMICS” цуврал уулзалт:

Монголын Хуульчдын холбооны Эдийн засгийн эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүдийн санаачилгаар хорооны гишүүдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өглөөний цайтай цуврал уулзалт, ярилцлагыг “**LAW AND ECONOMICS**” нэрийн дор зохион байгуулсан бөгөөд панелистаар “Мизес Монгол” ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн, хуульч, өмгөөлөгч Ц.Мөнхбат оролцож “**Л.Ф.Мизес: Дундыг баримтлах бодлого социализмд хөтөлнө**” сэдвийн хүрээнд илтгэл хэлэлцүүлж, эдийн засгийн онол урсгал, орчуулгын бүтээлийн талаар ярилцав. Уулзалтад Эдийн засгийн эрх зүйн хорооны 35



LAW AND ECONOMICS



СЭДЭВ: Л.Ф.МИЗЕС
“ДУНДЫГ БАРИМТЛАХ
БОДЛОГО СОЦИАЛИЗМД
ХӨТӨЛНӨ”



ЭДИЙН
ЗАСГИЙН
ЭРХ ЗҮЙН
ХОРОО

Панелист: “Мизес Монгол” ТББ-ын
Удирдах зөвлөлийн гишүүн, хуульч,
өмгөөлөгч Ц.Мөнхбат

ЦУВРАЛ УУЛЗАЛТ

Чингис хааны музейн
1 давхар
MNLB coffee shop
2023-03-17
(17:40 улс.)

LAW AND ECONOMICS #2/23



СЭДЭВ: ОЮУНЫ ӨМЧИЙГ
ҮНЭЛЭХ ХЭРЭГЦЭЭ
ШААРДЛАГА, АРГА ЗҮЙ



ЭДИЙН
ЗАСГИЙН
ЭРХ ЗҮЙН
ХОРОО

Панелист: Монголын Маргэсын
Үнэлгээний Институтын Удирдах
зөвлөлийн гишүүн, Аудитын хорооны
дарга, Тэргүүл үнэлэгч П.Баясан



ЦУВРАЛ
НЕТВОРКИНГ

Чингис хааны музейн
1 давхар
MNLB coffee shop
2023-05-05



ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН ХОРОО

“Law and Economics” цуврал уулзалтын ээлжит дугаарт Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн Удирдах зөвлөлийн гишүүн, Аудитын хорооны дарга, Тэргүүлэх үнэлгээчин П.Баянсан оролцож **“Оюуны өмчийг үнэлэх хэрэгцээ шаардлага, арга зүй”** сэдвээр илтгэл хэлэлцүүлээ. Уулзалтад Эдийн засгийн эрх зүйн хорооны 20 хуульч оролцов.



ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БҮЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ЭРХ ЗҮЙН АКТЫН ХҮРЭЭНД:

Монголын Хуульчдын Холбооны Эдийн засгийн эрх зүйн хороо, Захиргааны эрх зүйн хороо, Хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хорооноос санаачлан Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгтэй хамтран “Нийгмийн даатгалын багц хуулиудын шинэчлэн найруулгын төсөл”-ийн хэлэлцүүлгийг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулав.



Хэлэлцүүлгийн панелистаар Эдийн засгийн эрх зүйн хорооны тэргүүн Б.Баасандорж оролцохын зэрэгцээ **“Нийгмийн даатгалын орчны эрх зүйн шинэтгэл, хуулийн төсөлд өгөх шүүмж”** сэдвээр илтгэл хэлэлцүүлээ.



ДӨРӨВ. Эдийн засгийн эрх зүйн чиглэлээр сургалт зохион байгуулах хүрээнд:

1 Эрх зүй ба технологи-модуль II сургалт: Дижитал шилжилтийн хүрээнд мэдээллийн технологийн хэрэглээ өсөн нэмэгдэж буйтай холбоотойгоор мэдээллийн технологид суурилсан үйлчилгээ, бүтээгдэхүүний эрх зүйн орчны талаар мэдлэгийг эзэмшүүлэх, практикт үүсэж буй тулгамдсан асуудлыг шийдвэрлэж буй арга зам, сайн туршлагын талаарх мэдээллийг олгох зэргийн бус сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд МУИС-ийн ХЗС дээр зохион байгуулав.

Сургалтыг нээж Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, доктор П.Одгэрэл, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, доктор Б.Амарсанаа, МУИС-ийн ХШУС-ийн дэд профессор, доктор Ч.Алтангэрэл нар үг хэллээ. Сургалтад Эдийн засгийн эрх зүйн хорооны тэргүүн Б.Баасандорж “Виртуал хөрөнгийн эрх зүйн зохицуулалт”- (Виртуал хөрөнгө, IEO, ICO ялгаа), Эдийн засгийн эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Д.Ганхүрэл “Дижитал аккаунтын эрх шилжүүлэх”- (Фейсбүүк аккаунтыг арилжаалах, өв залгамжлуулах хүрээнд үүсэж буй эрх зүйн асуудлууд, гэрээний эрх үүргийг шилжүүлэх) сэдвээр сургалт орлоо.

Эрх зүй ба технологи – модуль II сургалт зохион байгуулагдана

СУРГАЛТ 2023 ОНЫ 5 ДУГААР САРЫН 19, 20-НЫ ӨДРҮҮДЭД ЗОХИОН БАЙГУУЛАГДАНА. ХҮНИЙ ТОО ХЯЗГААРТАЙ. ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН 2023 ОНЫ 2 БАГЦ ЦАГ ТООЦНО.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ



2. Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх хуульчдад эрх олгох сургалт:

Монголын Хуульчдын холбоо, Санхүүгийн зохицуулах хороо хамтран “Үнэт цаасны заах зээлд үйлчилгээ үзүүлэх хуульчдад эрх олгох” сургалтыг хамтран зохион байгуулдаг. Сургалт 2023 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд Эдийн засгийн эрх зүйн хорооны тэргүүн Б.Баасандорж “Хөрөнгийн зах зээл: Аудит, үнэлгээний эрх зүйн зохицуулалт” сэдвээр сургалт орлоо.



ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН ХОРОО

ТАВ. Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулсан спортын уралдаан тэмцээний хүрээнд:

5.1 .Монголын Хуульчдын холбооны ерөнхийлөгчийн нэрэмжит шатрын тэмцээнд амжилттай оролцов.

Монголын Хуульчдын холбооны 10 жилийн ойг тохиолдуулан Ерөнхийлөгчийн нэрэмжит шатрын тэмцээнийг 2023 оны хоёрдугаар сарын 18-ны өдөр хуульчдын дунд зохион байгуулсан. Оюуны спортыг түгээн дэлгэрүүлэх, хуульчдын ур чадварыг хөгжүүлэх, туршлага солилцох зорилготой тус тэмцээнд 14 хорооны 42 тамирчин оюун ухаан, ур чадвараа сорин өрсөлдсөнөөс гуравдугаар байрын шагналыг Эдийн засгийн эрх зүйн хорооны баг тамирчид /Д.Доржхорол,Ц.Мөнхбат, Г.Болормаа/ эзэллээ.



5.2 Монголын Хуульчдын холбооны шилжин явах цом-2023 спортын 6 төрөлт тэмцээн амжилттай оролцов.

Монголын Хуульчдын холбооны 10 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж байгаа Зөвлөл, Чиг үүргийн болон сайн дурын хороод, Тамгын газар, орон нутгийн салбарын гишүүдийн дунд спортын 6 төрөлт /Биллиард, дартс, боулинг, ширээний теннис, волейбол, сагсан бөмбөг/ тэмцээнийг 2023 оны тавдугаар сарын 11,12,13,14-ний өдрүүдэд “Ган спорт төв”-д зохион байгуулагдав.

Тэмцээнд Эдийн засгийн эрх зүйн хорооны дартс, биллиард, эрэгтэй сагсан бөмбөг, эрэгтэй гар бөмбөг, боулинг, теннисний баг тамирчид оролцов. Биллиардын төрөлд Эдийн засгийн эрх зүйн хороо гишүүн хуульч Г.Орхон мөнгөн медаль авч амжилттай оролцлоо.



ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХОРОО

2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр АНУ-ын Элчин сайд Ричард Буанган болон төлөөлөгчдийг хүлээн авч цаашид хамтарч ажиллах талаар санал солилцох уулзалт зохион байгуулсан. Тэрээр Олон Улсын эрх зүйн хорооны урилгаар Монгол Улс, АНУ-ын Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай хэлэлцээр болон Монгол Улсад хөрөнгө оруулах эрх зүйн орчны талаар санал бодлоо хуульчидтай хуваалцсан.



ӨМГӨӨЛЛИЙН НӨХӨРЛӨЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

НЭГ.Хорооны ээлжит болон ээлжит бус хурал

Өмгөөллийн нөхөрлөлийн хөгжлийг дэмжих хороо нь 01 сарын 26 болон 04 сарын 27-ны өдрүүдэд 2 удаа хуралдсан. Эхний хурлаар Хорооны 2023 оны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө болон, хорооны гишүүдийн дутуу орон тоог нөхөх сонгууль болон Хорооны тэргүүнийг сонгох, батламжлах тухай хэлэлцсэн. Хорооны гишүүдийн олонхын саналаар Д.Түвшинтамир хорооны тэргүүнээр сонгогдов.

Хорооны 2 дахь удаагийн хурлаар хорооны цаашид хийхээр төлөвлөж буй үйл ажиллагааны талаар болон “Хуульчдын шилжин явах цом-2023” тэмцээнд хорооны гишүүдийн нэрс, баг тамирчдын талаар ярилцав. Тус тэмцээнд дартс, боулинг, эрэгтэй сагсны төрөлд оролцсон ба дартсын төрөлд хорооны тэргүүн Д.Түвшинтамир, гишүүн С.Санчир нар хүрэл медаль авсан.

Мөн хурлаар Хуульчдын холбоонд бүртгэлтэй өмгөөллийн нөхөрлөлүүдийн шинэчилсэн мэдээллийг гаргах ажлыг зохион байгуулах талаар ярилцаж шийдвэрлэв.

ХОЁР. Бусад ажил

Хуульчдын холбооноос санаачлан “Хуульчдын төгөл”-тэй болох аяны хүрээнд хорооны гишүүд идэвхтэй оролцож Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 15 ширхэг мод тарив.

ӨМГӨӨЛЛИЙН НӨХӨРЛӨЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО





МОНГОЛЫН
ХУУЛЬЧДЫН
ХОЛБОО

Хуульчдын
Холбоо